

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хэрэгжилтийн хувь
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ</b>							
<b>1</b>	<b>Зорилт-1: Эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, хандлага, чиглэлийг боловсруулах</b>						
1.1	Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах	-	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувиар	Гүйцэтгэл 40 хувь	Гүйцэтгэл 60 хувь	Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг 2023 онд 8 бүлэг, 33 зорилт, 164 үйл ажиллагаатайгаар хэрэгжүүлж, 90.1 хувийн гүйцэтгэлттэй дүгнэгдсэн ба өмнөх оноос 10.1 пунктээр өссөн. Шалгуур үзүүлэлт хяналт шинжилгээ үнэлгээгээр 85.4 хувийн биелэлттэй бөгөөд өмнөх оноос 8.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.	100
1.2	Аймгийн 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	2022 оны гүйцэтгэл 90.8%	Тухайн жилийн гүйцэтгэл 100	Орхон аймаг, Эрдэнэт хотын 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг 8 бүлэг, 33 зорилт, 181 үйл ажиллагаатайгаар хэрэгжүүлж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар 90.9%-тай дүгнэгдлээ.	90
1.3	Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах, эрэмбэлэх, төлөвлөх, гүйцэтгэлд хяналт	Орон нутгийн төсөв	Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86-р тушаалаар батлагдсан	Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санал асуулга, хэлэлцүүлэг зохион	Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулж,	2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгыг холбогдох хууль, журамд нийцүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан Ажлын хэсэг болон аймгийн Засаг дарга Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр	100

	тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах.		журмыг хангаж ажиллана.	байгуулж, эрэмбэлэн төлөвлөсөн.	эрэмбэлэх, гүйцэтгэх	саналуудыг авч эрэмбэлэх ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Санаачилгатай Эрдэнэт хүн” төслийн хүрээнд нийт 18343 өрхийн саналыг /цахимаар 1947, утсаар 180, үйлчилгээний байгууллагын 1965, хаягаар 14251/ авсан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний танилцуулга контентыг олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчлах ажил хийгдсэн.	
1.4	Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2022 оны байдлаар шинэчилж оруулах; <a href="http://www.ldi.nda.gov.mn">www.ldi.nda.gov.mn</a>	-	Мэдээлэл оруулсан байх	Мэдээллийг оруулсан	Мэдээллийг шинэчлэн оруулсан байна	“Орон нутгийн хөгжлийн индекс” тооцох аргачлалын дагуу ерөнхий 5 төрлийн мэдээлэл, боловсролын салбарын 6 төрлийн мэдээлэл, эрүүл мэндийн салбарын 5, эдийн засгийн салбарын 5, дэд бүтцийн 7, байгаль орчны чиглэлээр 3, бусад 1 төрлийн тоон мэдээллийг Баян-Өндөр, Жаргалант сумын байгууллага, аж ахуйн нэгж бүрээр 2022 оны байдлаар гарган хуулийн хугацаанд нь цахим системд оруулж баталгаажуулсан.	100
1.5	Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	-	Гүйцэтгэлийн хувиар	-	70 хувь	Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор батлуулан, жилийн эцсийн байдлаар 84.7	70

						хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэн ажилласан.	
1.6	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төслийг батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих	-	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын худалдан авах ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна.	2023 оны хөрөнгө оруулалтын төслийг батлуулсан	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэх ажлын жагсаалт батлуулах	Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд 2 төсөл арга хэмжээний эрх шилжин орон нутагт хийхээр төлөвлөснөөс 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулсан. Орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 144 төсөл арга хэмжээний 144 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарсан байна.	100
<b>2</b>	<b>Зорилт-2: Аймгийн санхүү, төсвийн бодлого тодорхойлох, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих, төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</b>						
2.1	Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх, төсвийн урсгал зардлыг ил тод хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.	Орон нутгийн төсөв	Нягтлан бодогчдод төсвийн төлөвлөлтийн Фискал программын сургалт зохион байгуулж, төсвийн сар, улирлын хуваарийг нэгтгэх	Төсвийн бүх байгууллага удын төсвийн сар, улирлын хуваарийг Фискал программаар хүлээн авч нэгтгэдэг болсон	Дараа оны төсвийн төслийг тус Фискал программаар хүлээн авч, нэгтгэж Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэх.	Аймгийн 2024 оны төсвийн төслийг төсвийн төлөвлөлтийн фискал программаар нэгтгэн авч хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн. Аймгийн 2024 оны төсөв аймгийн ИТХаар батлагдсан даруйд төсвийн байгууллагуудаас сар улирлын хуваарийг 12 сарын 15-ны дотор фискал программаар нэгтгэн авч нэгтгэлийг хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа.	100
2.2	Төрийн сангийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар ханган, нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэгжүүлж, зохион байгуулах, хяналт тавих, төсвийн	Орон нутгийн төсөв	Төсвийн байгууллагуудын санхүүжилтийг журмын дагуу батлагдсан хуваариар олгосон байх	Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэлийн үр ашиг дээшилсэн байна.	Орон нутгийн төсөвт болон гүйцэтгэлийн байгууллагуудын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгох, зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байхад хяналт тавин ажилласнаар 2023 онд хэтрүүлсэн зарцуулалт байхгүй, төсөвтэй холбоотой өр, авлагагүй ажилласан. Мөн НББ-ийн стандартыг хэрэгжүүлэх ажлын	100

	гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлэх					хүрээнд нягтлан бодогчдод “УСНББОУ-ын стандарт”-ын сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, “Санхүүгийн тайлангийн аудит, анхаарах асуудлууд” сэдвээр аудитын байгууллагатай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
2.3	Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг түргэн шуурхай, чанартай хүргэх	Орон нутгийн төсөв	Аливаа хүнд суртал чирэгдэл үүсгэхгүй, иргэдээс гомдол санал гаргаагүй ажилласан байх	100%	ААН, байгууллагын тайланг 100% хүлээн авна.	Аж ахуйн нэгж байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 85,6 хувьтай хүлээн авч хянан баталгаажуулж, тайлан мэдээг хуулийн хугацаанд Сангийн яаманд цахимаар болон цаасаар хүргүүлсэн. ААНБ-н удирдлага болон нягтлан бодогч нарт цахим санхүүгийн тайлан И балансын шинэ системийн талаарх сургалтыг 4 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 250 иргэн хамрагдаж шинэ системд бүртгэлээ баталгаажуулсан. Шинэ системийн холболтын талаарх видео контентыг олон нийтийн цахим сүлжээ, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сайтуудаар дамжуулан олон нийтэд хүргэн, баталгаажуулалтыг хийж байна. 2023 оны хагас жилээр санхүүгийн тайлан өгөх нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын тайланг 95.5 хувьтай хүлээн авч хянан баталгаажуулсан. 2023 оны жилийн	100 Нэмэлт бичих
2.4	Харьяа төсөвт байгууллагуудын нягтлан бодогчдын	Орон нутгийн төсөв	НББ хөтлөлттэй холбоотой	-	мэдээ, санхүүгийн тайланг	Орон нутгийн харьяа 18 байгууллага, гүйцэтгэлийн 63 байгууллагын төсвийн зарцуулалт,	100

	бүртгэл хөтлөлт, тайлан мэдээнд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах		шинэ мэдээ мэдээлэл, гарын авлагаар хангах		хуулийн хугацаанд гаргаж хэвшсэн байна	нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан мэдээнд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу 100% хүлээн авч, хянаж баталгаажуулж хэвшсэн. “УСНББОУСтандарт”-ын сургалт, Татварын хууль, НД-ын багц хууль, бусад мэргэжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн 2023 онд харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөх “НББ-ийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан 2023 оны 6 дугаар сарын 1-ээс мөрдөн ажиллаж байна.	
--	---	--	--	--	--	---	--

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ДЭД БҮТЭЦ, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ**

<b>1</b>	<b>Зорилт-1: Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.</b>						
1.1	Инженерийн хангамжтай нийтийн орон сууцны хорооллуудыг гэр хорооллын багуудад барьж аймгийн орон сууцны нэмэгдүүлэх	Орон нутгийн болон Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч	Уртын гол багт шинээр орон сууц барилга угсралтын ажлын хувь	2022 онд 3 блок буюу 156 айлын орон сууц ашиглалтад ороход бэлтгэл хангагдаж байна.	5 блок, 260 айлын орон сууцны ажлын гүйцэтгэл 80 хувь	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажил хийгдэж байна. 5 блок барилгын А блок 70 хувь, D блок 80 хувь, Е блок 12 хувийн гүйцэтгэлтэй, В,С блок ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээлгэн өгснөөр тус төсөл 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар ашиглалтад	100

						орсон 2 блок барилгад нийт 70 айл орсон. Төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан.	
1.2	Амины орон сууцны хорооллуудыг барьж, аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, хувийн хэвшил	Ашиглалтад оруулсан амины орон сууц	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хороолол баригдаж төлөвлөгөөн ий дагуу 45% гүйцэтгэлтэй явагдаж байна.	Хэрэгжилт 80% болсон байна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 55 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 863 айлын 15 төсөл Оюут, Цагаан чулуут, Найрамдал, Зэст багуудад тус тус баригдаж байгаагаас одоогийн байдлаар 448 айлын орон сууц ашиглалтад орсон.	70
<b>2</b>	<b>Зорилт-2: Гэр хорооллын багуудын дахин төлөвлөлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам /халаалт, цэвэр бохир/-д холбож барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</b>						

2.1	Дахин төлөвлөх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	Орон нутгийн төсөв	Ажлын хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах асуудлыг хэлэлцүүлсэн байна.	Зургийг боловсруулж батлуулсан	Ажлын гүйцэтгэлээр	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар дахин төлөвлөлтийн асуудлыг хэлэлцүүлж, Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг батлуулсан. Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажлын хэрэгжилт 30 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл хийгдэж байна. Дахин төлөвлөх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт зарласан. Оюут багийн Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10 га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.	70
2.2	Хот байгуулалт, газрын харилцааны цахим мэдээллийн санг сурталчлах	Гадаадын төсөл	Цахим мэдээллийн санд орсон үйлчилгээний тоо	Газрын харилцааны цахим мэдээллийн санд орсон	Цахим мэдээллийн санд орсон үйлчилгээний тоо 25	Хот байгуулалт, газрын харилцааны цахим мэдээллийн санг сурталчлах ажлын хүрээнд <a href="http://www.egazar.gov.mn">www.egazar.gov.mn</a> газрын цахим системийг сурталчлах Нээлттэй хаалганы өдөрлөгийг	100

	<p>ажлыг зохион байгуулах</p>			<p>үйлчилгээний тоо 17</p>		<p>Баян-Өндөр сумын 16 багт, Жаргалант сумын 3 багт зохион байгуулж egazar цахим системийн танилцуулга гарын авлагыг бэлтгэж тараасан. Төрийн байгууллагуудын нэгдсэн нээлттэй хаалганы өдөрлөгт хот байгуулалтын Urban.gov.mn цахим сайтыг сурталчлан ажилласан. ГХБХБГ-ын цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр 2023 оны аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл, түүнтэй холбоотой хууль эрх зүйн мэдээлэл, цахим үйлчилгээг сурталчилж 36546 хандалтыг авсан байна. Газрын харилцааны цахим шилжилтийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор 2 ширхэг цахим үйлчилгээний киоск төхөөрөмж, буюу egazar цахим системийн өөртөө үйлчлэх ухаалаг төхөөрөмжийг ажиллуулж байна. Тус киоск төхөөрөмж нэвтэрснээр иргэд аж ахуйн, нэгж байгууллагууд газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв хянан баталгааны дүгнэлт, газрын барьцаа, төлбөрийн мэдээлэл зэрэг 18 төрлийн үйлчилгээг хурдан хугацаанд авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	
--	-----------------------------------	--	--	--------------------------------	--	---	--



						Газрын харилцааны цахим мэдээллийн сан, хот байгуулалтын Urban.gov.mn цахим сайтаас иргэд, аж ахуйн нэгж байгууллага 23 төрлийн үйлчилгээг цахимаар авч байна.	
3	<b>Зорилт-3: Гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр”, орон сууцны хорооллын багуудад “Миний орц-Бидний байшин” төслүүдийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, камержуулалтыг үе шаттайгаар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ</b>						
3.1	Гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр” төслийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Орон нутгийн хөгжлийн сан	Өрхийн тоо	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 431	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 640-д хүрнэ.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын дараах 7 багт инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Үүнд: Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.94 км, цэвэр усны 0.94 км, бохирын 0.5 км, Рашаант багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдлээ. Төслийн үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж, 253 айл өрх бүрэн холбогдсон.	100
3.2	Орон сууцны хорооллын багуудад “Миний	Орон нутгийн төсөв	Аюулгүй, тохилог орчин бүрдэнэ.	Төслийг боловсруулсан.	Тохилог, иргэдийн ая тухтай амьдрах	"Миний орц-Бидний байшин" төслийн хүрээнд 14 орцны засварын ажилд орон нутгийн төсвөөс 379.5	100

	орц-Бидний байшин” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх				орц ашиглалтад орсон байна.	сая төгрөг зарцуулсан. Үүнд: Дэнж багийн 3 байрны 6 орцны засварын ажлыг “Алист констракшн” ХХК, Баянцагаан багийн Вокзалын 3, 4 дүгээр байрны 8 орцны засварын ажлыг “Өвөлжөөн булаг” ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад орууллаа.	
<b>4</b>	<b>Зорилт-4: Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлнэ.</b>						
4.1	“Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд цахим төлбөрийн карт нэвтрүүлэх	Орон нутаг болон хувийн хэвшил	Цахим карт бүрэн нэвтэрсэн байна.	-	Хэрэгжилт 100 хувь	Аймгийн Засаг дарга "Сим" ХХК-тай нийтийн тээврийн үйлчилгээнд Цахим картын үйлчилгээ буюу E-Pass төслийг хэрэгжүүлэхээр 2021 оноос хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжих хугацаанд 36 автобусанд карт унших төхөөрөмж, спикер, 20 буудалд зарлан мэдээлэх төхөөрөмж, 21 автобусанд дэлгэц, 36 автобусанд хяналтын болон хүн тоологч нийт 72 ширхэг камер, дэлгэцийг байршуулсан. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдэд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран 6000 ширхэг картыг олгосон бөгөөд 2 байршилд карт худалдан борлуулах, мэдээлэл өгөх түр төвийг байгуулж иргэдэд карт олгох ажлыг зохион байгуулсан. Эрдэнэт ШУТПарк нь Цахим Эрдэнэт-1 хөтөлбөрийн хүрээнд Smart Erdenet аппликейшнд суусан нийтийн тээврийн цэсийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	90

5	<b>Зорилт-5: Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто буудал байгуулж, зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлнэ.</b>						
5.1	Зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн “Авто буудал” байгуулах ажлыг эхлүүлэх	Улсын төсөв	Ажлын гүйцэтгэлээр	-	Барилгын ажил эхэлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Шинжүү” ХХК нь орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ын барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2023 оны төсөвт өртөг 3.9 тэрбум төгрөг ба барилгын ажлын явц 80 орчим хувьтай үргэлжилж байна. Гадна ИШС-ний ажил, дотор цахилгаан, агааржуулалтын холболтын ажлууд бүрэн дууссан. Дотор заслын ажлууд хийгдэж байна.	100
6	<b>Зорилт-6: Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна.</b>						
6.1	Хот доторх авто замын нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттайгаар хийх	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.	Хот доторх авто замын нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттайгаар хийж эхлүүлсэн.	3000 м.кв талбайд нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн байна.	2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр хорооллын 18 дугаар байрны арын замыг 160м тусгаарлах хашаа, Эрдэнэ багт авто зам дагуу 144 м туузан хашлага, сургууль цэцэрлэг орчмын явган хүний гарц, сургууль орчмын бүсийн тэмдэг, гэр хороолол, төв зам дагуу нийт 125 ширхэг босоо тэмдгийг 33.8 сая төгрөгөөр, Барилгачдын талбайн уулзвараас 5-р хорооллын уулзвар хүртэлх 17724 м газарт авто замын хэвтээ тэмдэглэгээ, сургууль цэцэрлэг орчмын 103 байршилд 22703 м явган хүний гарцын тэмдэглэгээг тус тус 256.5 сая төгрөгөөр хийж бүрэн дууссан. 2023 онд нийт 16512 м2 талбайд халуун асфальт бетоноор 1.28 тэрбум төгрөгөөр, 40427м хэвтээ тэмдэглэгээ, 125ш авто замын босоо	100

						тэмдэг, тэмдэглэгээ, туузан хашлагыг 1.57 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	
<b>7</b>	<b>Зорилт-7: Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.</b>						
7.1	Тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үе шаттай зохион байгуулах	-	Төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн байна.	Төлөвлөгөө боловсруулагдсан.	Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн ИТХ-ын 2022 оны 13/06 дугаар тогтоолоор “Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл”-ийг батлуулан 9 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж, Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн Газар зохион байгуулалтын талаар хэрэгжүүлэх зорилт, заалтууд 100 хувь бүрэн хэрэгжсэн.	100
7.2	Газрын биржийн үнийн судалгаа, газар өмчлөх, эзэмших, ашиглах иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд хамруулах	-	Бүртгэсэн нэгж талбарын тоогоор	Бүртгэсэн нэгж талбарын тоо 3500	Бүртгэсэн нэгж талбарын тоо 4000	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь Газрын биржийн www.mle.mn цахим системээс гэр бүлийн хэрэгцээ, худалдаа үйлчилгээ, ХАА-н үйлдвэрлэл, ХАА-аас бусад үйлдвэрлэлийн гэсэн газар ашиглалтын 4 зориулалтаар бүртгэгдсэн үнийн мэдээний тоо, дундаж үнэ, хамгийн бага үнэ, их үнэ, үнийн мэдээний эзлэх хувь, төрөл, эх сурвалж, эрхийн төрлийн тоон мэдээллүүдийг авах боломжтой. Мөн Улсын хэмжээнд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаар мэдээ мэдээлэл авч, дуудлага худалдаанд оролцох бүрэн боломжтой юм. 2023 онд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ	100

						шилжүүлсэн 721 нэгж талбар, нийт өссөн дүнгээр 4607 нэгж талбарын үнийн мэдээг газрын биржийн www.mle.mn цахим системд бүртгээд байна. Газрын биржийн цахим системийг олон нийтийн цахим сүлжээгээр болон гарын авлага бэлтгэн иргэдэд сурталчлан ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--	--

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ**

<b>1</b>	<b>Зорилт-1: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.</b>						
1.1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах "Хөгжлийн шийдэл" ТББ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/	Орон нутгийн төсөл	Холбогдох байгууллагатай хамтран ажилласан байна.	-	Хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан байна.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл, хөтөлбөрүүдтэй холбогдох чиглэлээр хамтран ажиллаж хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрхзүйн мэдлэг, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах хөтөлбөрт сургалтыг Best хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийн ажилтнуудыг 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертификатжуулсан. 2023 онд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих GIZ-PROGRESS төслөөс 15 аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт, "Хөгжлийн шийдэл" Төрийн бус	100

						байгууллагын BEST хөтөлбөрөөс 5 аж ахуйн нэгжид 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Жайка төслөөс 4 төсөлд 3.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад Прогресс төслөөс 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
1.2	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл хүссэн өргөдөл, материалыг хүлээн авах, арилжааны банкуудад уламжлах	Хувийн хэвшил	Дэмжлэг үзүүлсэн байна.	-	Зээл хүссэн өргөдлийг хүлээн авч холбогдох газарт хүргүүлсэн байна.	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 5 аж ахуйн нэгжид 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 хоршоо, аж ахуйн нэгж, иргэнд 500.0 сая төгрөгийн зээл олгосон. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 24 аж ахуйн нэгж, 18 иргэнд 14.4 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих сангаас 2012 оноос эхлэн зээл олгож эхэлсэн бөгөөд аймгийн болон банкны эх үүсвэрээс бүрдсэн нийт 1.3 тэрбум төгрөгийн сантай. Тус сангаас жилийн 10-12 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай, зээлийн хэмжээ 50.0 сая хүртэл, эхний 3 сар үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй Хаан, Төрийн, Капитрон банкуудаар дамжуулан зээл гарч байгаа бөгөөд энэ онд 6 аж ахуйн нэгж, иргэнд 274.0 сая төгрөгийн зээл олгогдсон.	100

						Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олголтыг хялбарчлах зорилгоор “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөртэй хамтран холбогдох төрийн байгууллагууд, банкуудыг оролцуулан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулснаар хөнгөлөлттэй зээл олгох журмыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.	
<b>2</b>	<b>Зорилт-2: Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.</b>						
2.1	“Өрхийн болон бичил үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хөтөлбөрийн хэрэгжилтээр	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувь	Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр” батлуулан 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн, дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр хөтөлбөрийн хэрэгжилт 35.0 хувьтай байна. Өрхийн үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах болон сүү боловсруулах чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч нийт 880 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. “Бялхам Ивээл” ХХК-тай хамтран “Хөдөө аж ахуй технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэнийг, Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан.	100

						"Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцлоо.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.</b>						
3.1	Залуучуудыг хамруулсан гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжсэн гарааны бизнесийн тоо	Гарааны 5 бизнес санааг дэмжсэн.	Гарааны 5 бизнес санааг дэмжин хөгжүүлнэ.	2023 онд "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацийн төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан шилдэг оролцогч 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж, 1 төсөлд 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, гарааны бизнесийн хөтөлбөрт оролцох сонирхолтой 20 оюутны баг бүрдүүлэн зөвлөн ажиллаж байна. "Гарааны бизнес-2023" төслийн хүрээнд 33 өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчид тус бүр 5.0 сая, хүнсний болон ногоон сууцны үйлдвэрлэлийн 3 төсөлд тус бүр 35.0 сая, нийт 270.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй "Код лаб" сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон. Тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтад хамруулж чадавхжуулсан.	100



						Одоогийн байдлаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас 17 гарааны бизнесийг дэмжин хөгжүүлээд байна.	
3.2	Орон нутгийн ЖДҮ болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн төрөлжсөн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, түншлэл хийх, туршлага солилцох ажилд оролцох	Орон нутгийн төсөв	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байх	2 удаа зохион байгуулсан.	Хавар, намрын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	“Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023” үзэсгэлэн худалдаа 3 хоног зохион байгуулагдаж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцлоо. Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан. Дархан хотод 2023 оны 5 дугаар сард зохиогдсон Оросын Зам барилга, ХАА-н машин механизмын үзэсгэлэнгийн арга хэмжээнд Орхон аймгийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Манжуур хотын Ардын Засгийн ордны даргаар ахлуулсан баг төлөөлөгчид Орхон аймагт 2023 оны 04 дүгээр сард айлчилж Орхон аймаг Манжуур хотын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2023-2025 оны хооронд хийх ажлын төлөвлөгөөг баталж хамтын ажиллагааг эрчимжүүлэн ажиллахаар тохиролцсон байна. Монгол-Чехийн бизнес форум 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулагдаж, Орхон аймгаас Худалдаа аж үйлдвэрийн танхимын бизнес эрхлэгч 6 аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүд оролцлоо.	90
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ							
1	<b>Зорилт-1: Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.</b>						

1.1	"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Орон нутгийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулсан.	Хэрэгжилт 90 хувь	"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулан ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 85.7 хувийн гүйцэтгэлтэй байна.	90
<b>2</b>	<b>Зорилт-2: Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.</b>						
2.1	Хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн, баталгаажуулалтын түвшинг нэмэгдүүлэх.	Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил	Баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдсэн байна.	Баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээ 40%	Баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээ 50%	2023 оны байдлаар "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдгийг талх, нарийн боовны 3 үйлдвэрийн 4 нэр төрлийн 52 нэрийн бүтээгдэхүүнд олгосноор нийт 7 хүнсний үйлдвэрийн 6 нэр төрлийн 56 нэрийн бүтээгдэхүүн эзэмшиж байна. Засгийн газраас баталсан "Техникийн зохицуулалт"-ын шаардлагыг хангаж аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг бүхий махны 3, сүүний 3, бялуун бүтээгдэхүүний 11, нийт 17 иргэн, аж ахуйн нэгжийн цех, үйлдвэр байгаагаас тохирлын үнэлгээнд хамрагдсан "Жүр үр" ХХК нь аюулгүйн тэмдгийг 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд хэрэглэх эрх авч, нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн 5.8 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна. Аймгийн хэмжээнд нийт 5 аж ахуйн нэгж, байгууллагын 8 үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт хэрэгжүүлэх ажил хийгдэж байгаагаас "Хаан хүнс картеринг" ХХК, "Эрдмийт" ХХК Хүнсний аюулгүй байдлын	100

						менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 /НАССР/ стандартаар, "Жаргалант мах маркет" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК, "Эрдмийт" ХХК MNS SAC /RCP 1:2003 (НАССР) стандартаар тус тус гэрчилгээжсэн. "Жаргалант мах маркет" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК-д нь ISO:22000 стандартын 2 дахь шатны аудитад орсон. "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим "(олон улсын зөвлөмж) MNS SAC/ RCP 1:2003 стандартыг усны 1 үйлдвэр, нийтийн хоолны 2, талхны 2 үйлдвэр хэрэгжүүлж эхлээд байна.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.</b>						
3.1	Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавьж ажиллах.	Орон нутгийн төсөв	Борлуулсан махны хэмжээ	2022 онд 150 тн мах борлуулсан	300 тн мах борлуулна	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 махны үйлдвэр өөрсдийн нэрийн дэлгүүрээр 150 тн мах зах зээлд нийлүүлснээр 2023 хаврын улиралд аймгийн хэмжээнд махны хомсдол үүсээгүй. "Өвлийн идэш" арга хэмжээгээр иргэд 63.5 тонн малын мах худалдан авснаар өвлийн идшээ хямд нөөцлөх боломж бүрдсэн.	70
<b>4</b>	<b>Зорилт-4: Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.</b>						
4.1	Газар тариалангийн ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах	Орон нутгийн төсөв	Тариалсан ургацын хэмжээ	Үр тариа 4779 га, тэжээл 284 га, тосны ургамал 197 га, төмс 273 га, хүнсний ногоо 503 га, жимс 1,3 га,	Гүйцэтгэлээр	Аймгийн хэмжээнд 5364 га талбайд тариалалт хийхээр төлөвлөснөөс 12 аж ахуйн нэгж, байгууллага, 563 өрх нийт 5584 га талбайд тариалалт хийж, үүнээс үр тариа 3904 га, малын тэжээлийн ургамал 287, тосны ургамал 821 га, төмс 146 га, хүнсний ногоо 426 га-д тариалж,	100

				нийт 6037,3 га-д тариалсан		уринш боловсруулалт 3600 га талбайд хийж гүйцэтгэсэн. Үр тариа 3904 га талбайгаас 10892 тн буюу га-аас 28 цн ургац үүнээс улаан буудай 3805 га талбайгаас 10752 тн буюу 28 цн ургац, төмс 145 га талбайгаас 1628 тн буюу га-аас 112 цн, хүнсний ногоо 455.2 га талбайгаас 9520 тн буюу га-аас 209 цн, тэжээлийн ургамал 287 га талбайгаас 1122 тн буюу га-аас 39 цн, тосны ургамал 821 га талбайгаас 300 тн буюу га-аас 3.7 цн ургац тус тус хураан авсан. Ургац хураалтын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.	
<b>5</b>	<b>Зорилт-5: Үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.</b>						
5.1	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв	500 өрх хамруулах	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэгч 500 өрх дэмжлэгт хамрагдсан байна.	500 өрх хамруулна	“Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төмс, хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хан төгөл хайлааст” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газраас баталгаажуулан ирүүлсэн 26 багийн нийт 500 өрхөд төмс, хүнсний ногооны тариалалт хийх технологийн сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 500 өрхөд 40.0 сая	100

						<p>төгрөгийн санхүүжилтээр төмсний 20 тн үр, хүнсний ногооны 5 төрлийн үрийн багц буюу нийт 90 кг-ийг олгож, технологит ажлын гарын авлага, зөвлөмжөөр ханган ажилласан. Мөн Засгийн газрын 2022 оны “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 118 дугаар тогтоолын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас манай аймагт 13 төрлийн 2.6 тн хүнсний ногооны үр хуваарилсныг орон нутагт татан авч сумын Засаг даргын Тамгын газраар дамжуулан нийт 5 аж ахуйн нэгж, 230 өрхөд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон. Жаргалант сумын Бөөн бургаст 3.6 км хашаа шинээр барьж, 36 дугаар точикт 5.1 км хашаа сэргээн засварлахаар бэлтгэл хангаж байна. Агропаркийг түшиглэн төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай зоорь барих ажлыг “Сэнгүн констракшин” ХХК гүйцэтгэж байна.</p>	
<b>6</b>	<b>Зорилт-6: Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.</b>						
6.1	Малын эрүүл мэнд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	70 хувь хэрэгжсэн	90 хувь хэрэгжинэ	<p>“Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 96.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 109.1 мянган толгой малыг 10 төрлийн вакцинд хамруулахаар төлөвлөж 111.9 мянган толгой мал, амьтныг хамруулсан.</p>	100

						<p>Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 102.4 мянган толгой бог мал хамруулж 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.</p> <p>Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад нийт 51.3 мянган толгой мал, амьтан хамруулж 100 хувьтай хэрэгжсэн.</p> <p>Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 192.0 мянган толгой мал хамруулахаас нийт 197.6 мянган толгой мал сүргийг хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн.</p>	
6.2	Улс, аймгийн аварга малчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Хүндэтгэл үзүүлсэн байна	2022 оны улс, аймгийн аварга малчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлсэн	Холбогдох арга хэмжээг авч ажиллах	<p>Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн Ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн “Улсын аварга малчин, улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланч шалгаруулах тухай”, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу мал аж ахуй, газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажилласан улс, аймгийн аварга малчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсан.</p>	100
7	<b>Зорилт-7: Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж нийтийн эрүүл мэндийг хамгаална.</b>						
7.1	Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицидийн	Сум, Орон нутгийн төсөв	Шинжилгээний хэрэгжилтээр	7 төрлийн эмийн болон бусад үлдэгдэл, шинжилгээг	Эмийн болон бусад үлдэгдэл, шинжилгээг элиза болон	Мал эмнэлгийн лабораторид мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дээжид Антибиотикийн үлдэгдлийг тодорхойлох магадлан	100

	үлдэгдлийг тодорхойлох, малын эмийн зохистой хэрэглээг хангах			хийж гүйцэтгэсэн.	туузан сорилын урвалаар хийж гүйцэтгэх	шинжилгээнд 12 аж ахуйн нэгж (давхардсан тоогоор), 24 иргэн, 19 цэцэрлэг, 3 сургуулийн 155 дээж хамруулахад эмийн үлдэгдэл илрээгүй.	
7.2	Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсвөөс	Хэрэгжилтийн хувь	2022 онд ариутгалыг 527.7 мянган м.кв талбайд хийсэн.	2023 онд 530.0 мянган м.кв талбайд хийнэ	Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 2458 мал, амьтны сэг зэмийг устган 565.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 14.3 сая төгрөг зарцуулсан.	100
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ</b>							
<b>1</b>	<b>Зорилт-1: Гэр хороололд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх, усны зөв хэрэглээний талаар бүх нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.</b>						
1.1	Гэр хорооллын нүхэн жорлонг эко ариун цэврийн байгууламжаар өөрчлөх ажлыг үргэлжлүүлэх	Орон нутгийн төсөв	Эко ариун цэврийн байгууламжийн тоо нэмэгдсэн байна.	673 өрх хангагдсан.	Эко ариун цэврийн байгууламжийн тоо 300	Гэр хорооллын айл өрхөд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн суурийн байгууламжийг барьж, гүйцэтгэх 2023 оны БЗА-65/23 гэрээт ажлын гүйцэтгэгчээр “Би Юу Эм Ди” ХХК ажиллаж, орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр гэр хорооллын 12 багийн нийт 45 өрхөд соруулдаг технологитой эко ариун цэврийн байгууламжийн суурийн хэсгийг иж бүрэн хийж дууссан. БЗА-41/22 гэрээт ажлын гүйцэтгэл он дамжин хэрэгжиж 2023 оны 8 дугаар сард нийт 78 өрхийн суурийн байгууламжийг бүрэн хийж, хаяавч бетоныг цутгаж, улсын комисс ажиллаж хүлээж авлаа. Мөн өөрийн хөрөнгөөр гэр хороололд 4 өрх стандартын	100

						шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хийсэн. 2023 оны байдлаар нийт 1718 ширхэг эко ариун цэврийн байгууламжийг шинээр барьж, ашиглалтад орууллаа.	
<b>2</b>	<b>Зорилт-2: Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ.</b>						
2.1	Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв	Агаар дахь PM тоосонцорын дундаж агууламжийн хэмжээ	Агаар дахь PM тоосонцорын дундаж агууламж стандартаас давсан.	Агаар дахь PM тоосонцорын дундаж агууламж MNS4585:200 стандартын түвшинд байх	Агаарын чанарын 2023 оны хүйтний улирлын хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 21 мкг/м3 буюу агаарын чанарын MNS4585:2016 стандартаас хэтрээгүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 126 мкг/м3, стандартаас хэтрээгүй боловч хотын төв орчим нийт хэмжилтийн 30% нь хүлцэх агууламжаас давсан байна. PM2.5 тоосонцорын агууламжийн дундаж дүн 0.0682мг/м3 хүрч стандартаас 1.4 дахин, хотын төв орчим нийт хэмжилтийн 80%, гэр хороолол орчим 63% нь хүлцэх агууламжаас давсан байна. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 166 өрх өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалт нэвтрүүлснээс гадна олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран нэмэлтээр Монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг нийт 109 өрхөд олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог 275-аар буурууллаа.	70
2.2	Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг	Эрдэнэт	Цагаан тоосны дэгдэлтийн бууралтын хувь	Цагаан тоосны дэгдэлтийн	Цагаан тоосны дэгдэлтийн бууралт 80 хувь	Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ, ЗДТГ, мэргэжлийн байгууллагууд	100



	<p>бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>үйлдвэр ТӨҮГ</p>		<p>бууралт 56 хувь</p>		<p>хамтран Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хаягдлын аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай газар дээр нь танилцаж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийн талаар нээлттэй уулзалт зохион байгуулсан ба цаашид хөтөлбөр төлөвлөгөөг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн тул шинэчлэн, боловсруулж, нөлөөллийн бүсийн багуудын ИНХ-аар хэлэлцүүлээ.</p> <p>Цагаан тоосны сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 67 дугаар тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хаягдлын аж ахуйг нүүлгэн шилжүүлэх чиглэл өгсний дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас хаягдал өтгөрүүлэх технологийн ТЭЗҮ-г боловсруулан батлуулж, 2027 онд ашиглалтад оруулахаар технологийн ажил хийгдэж байна.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, зорилгоор тоос дарагч 3 төрлийн бодисыг устай хольж тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж ашиглан хуурайшилттай талбайд цацах, хаягдал булингд хольж өгөх, үйлдвэрийн технологийн аргуудыг хослуулан Хаягдлын аж ахуйн тоос идэвхтэй дэгддэг 1100 га</p>
--	--	---------------------	--	------------------------	--	---

						хуурай талбайн 85%-ийг тогтмол дарж ажиллалаа.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.</b>						
3.1	Сумын ЗДТГ, Их шүтээн, Монгол ёс заншлын өргөө, Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолбор зэрэг газруудтай хамтран ажиллах	Орон нутгийн төсөв	Аялал жуулчлалын хөтөлбөрийн хэрэгжилтээр	-	Аяллын шинэ хөтөлбөр, маршруттай болсон байна.	Баян-Өндөр сумын ЗДТГ нь Ёс заншлын өргөөг түшиглэн ЕБС-ын сурагчдыг хамруулан Монгол ахуй, соёл, түүх, Монгол хүний амьдралын мөн чанарыг хүүхэд багачуудад танин мэдүүлж, ойлгуулах зорилгоор "Хөдөлмөр" зуслан ажиллуулж байгаа ба Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн амралтын бүсэд монгол хоолны газар, бага насны хүүхдүүдийг саатуулах хэсэг, элсэн дээр тоглох талбай, хүрээлэнгийн план зураг, самбар, 12 цэгт 48ш зүг чиг, таних тэмдэг хийж байршуулсан. БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын отоглох цэгүүдэд аялагч, түр амрагч нарт зориулан стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хогийн цэг байгуулж, тухайн орон нутгийн хөрс, гүний усны бохирдол, хог хаягдлыг бууруулж, байгаль орчныг хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 6 байршилд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аялал жуулчлалын түр буудаллах цэг /Эрдэнэт хаалга орчимд/-ийн нийтийн ариун цэврийн байгууламжид зориулсан гүний худаг шинээр гаргах байршлыг	100

						<p>мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлсон ба нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн сав бүхий 3.5x7м урттай эко ариун цэврийн байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа.</p> <p>Их шүтээн цогцолборт 2023 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд авто замын зогсоол, 108 шатыг шинэчлэх, гэрэлтүүлгийн ажлыг нийт 524 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан ба 1ш суваргыг иргэдийн хандив тусламжаар барьж дуусгаад байна. Мөн уул уурхайн 5 компанийг түшиглэн Зэс фестиваль арга хэмжээг 18 аж ахуйн нэгж байгууллагыг оролцуулан зэсийн үзэсгэлэн худалдаа, түүхэн замнал, зэс бүтээгдэхүүний ач холбогдол онцлогийг илэрхийлсэн олон талт арга хэмжээ, үйлдвэрийн аяллыг зохион байгуулж нийт 12 мянган хүнийг хамруулсан.</p>	
<b>4</b>	<b>Зорилт-4: Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.</b>						
4.1	Амрагч, жуулчдад шаардлагатай мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлсэн цэгийг бий болгох	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтээр	-	Цахим цэг бий болгоно.	<p>Аймгийн зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүх дурсгал зэрэг мэдээллийг багтаасан аялал жуулчлалын welcome.erdenet.mn веб сайтаар мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлээд байна. Мөн Орхон аймгийн Байгаль орчин,</p>	100

						<p>аялал жуулчлалын газар пэйж хуудсаар дамжуулан Welcome to erdenet видео контент болон аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг нийт 9300 орчим хүнд хүргэн ажиллалаа. Монголд зочлох жилийн хүрээнд БОАЖЯ, Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг зам дагуух 3 самбарт байршуулан бүх нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна. ITM-2023 аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн танилцуулга мэдээлэл, видео бичлэгийг цахимаар хүргэх ажлыг киоск, VR төхөөрөмжийн тусламжтайгаар бүх нийтэд хүргэсэн. Смарт Эрдэнэт апплекейшнд Орхон аймаг, Эрдэнэт хотын аяллын талаарх зочид буудал, ресторан, музей, үзвэр үйлчилгээ, аялал жуулчлалын маршрут, кофе шопын мэдээ мэдээллийг байршуулсан.</p>	
<b>5</b>	<b>Зорилт-5: Ногоон-Эрдэнэт төслийг хэрэгжүүлэн, аймгийн ногоон байгууламж, мод бутны хэмжээг нэмэгдүүлнэ.</b>						
5.1	<p>“Ногоон Эрдэнэт” төслийн хүрээнд Эрдэнэт хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар мод тарьж, ойн төгөл, зурвас байгуулах, хамгаалалтын хашаа хийх</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Таримал ойн талбайн хэмжээ</p>	<p>Суурьшлын бус газрын таримал ойн 42.5 га талбайд 321 мянган ширхэг тарьсан.</p>	<p>Суурьшлын бус газрын таримал ойн 82.5 га талбайд 471 мянган ширхэг мод тарина.</p>	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд мод тарих хүсэлтэй иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор мод бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, мод тарих хар шорооны нөөцийг бүрдүүлэх болон усалгааны систем зэрэг бэлтгэл ажлуудыг ханган ажилласан. Бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлын хүрээнд Дэнж багийн нутаг дэвсгэр, Тарлан</p>	70

						<p>толгойн энгэр суурьшлын бүсэд 17.5 га талбайг хашаажуулж, ойн төгөл байгуулахаар мод тарилтын ажлыг зохион байгуулсан. Хүрэнбулагийн аманд "Гэр бүлийн ойн төгөл", Жаргалант суманд 6.6 га талбайд газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал голын дагуу, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх зэрэг газруудад олон нийтийн оролцоотой 12.66 га, талбайд мод тарих ажлыг шат дараатайгаар зохион байгуулж, таримал ойн хэмжээг 36.76 га талбайгаар нэмэгдүүлж, нийт өссөн дүнгээр 92.76 га талбайд мод тарьж, ойн төгөл, ойн зурвас байгуулж, нийт 1,888,068 ширхэг мод тарилаа.</p> <p>"Ногоон-Эрдэнэт" болзолт уралдааныг зарлаж, уг уралдаанд 176268 ширхэг мод тарьж, ургуулж, орчны ногоон байгууламж нэмэгдүүлсэн 68 иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулж 20.0 сая төгрөгийн урамшууллыг олгосон.</p>	
5.2	<p>"Ногоон Эрдэнэт" төслийн хүрээнд жилд ойжуулах талбайн хэмжээг 25 га-д хүргэх, хэрэгцээтэй тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх</p>	Орон нутгийн төсөв	Ойжуулсан талбайн хэмжээ	Ойжуулсан талбайн хэмжээ 126 га	Ойжуулсан талбайн хэмжээ 224 га	<p>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Тарлан толгойн энгэрт 17.5 га талбайд ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га талбайд газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэнбулагийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд, Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр Сайвар хээр ХХК Баян-Өндөр уулын Цагаанчулуутын амны оройд 4 га талбайд ойжуулалт хийлээ. Мөн</p>	100

						Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ойн мэргэжлийн байгууллагаар Жаргалант сумын Хонгор морьтын амны ойн сангийн 48 га талбайд ойжуулалт гүйцэтгүүлж, шинээр 88.76 га талбайд ойжуулалт хийсэн.	
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН НИЙГМИЙН САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРУУЛАН, ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ БИЕЛЭЛТЭД НЬ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ</b>							
<b>1</b>	<b>Зорилт-1: Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.</b>						
1.1	Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	70,0 сая	Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн хувь	17%	17,2%	Тайлант хугацаанд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 110 иргэнд 44.2 сая төгрөгийг олгосон байна. Тайлант хугацаанд хавдрын 159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69.2 хувь нь хамрагдсан байна.	100
1.2	“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	10,0 сая	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	3	6	Тайлант хугацаанд шинээр 5 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болж, 4 байгууллага зэрэглэл ахиулсан байна. 21 төрийн байгууллагын 1180 албан хаагчийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдааныг 10 байгууллагын 60 хүнийг хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93.4 кг жин хаясан байна.	100

						Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 81 байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 12, бусад 10 байгууллага байна. 2023 оны байдлаар 1-зэрэглэлтэй эрүүл мэндийг дэмжигч байгууллага- 28, хоёрдугаар зэрэглэлтэй эрүүл мэндийг дэмжигч байгууллага- 26, гуравдугаар зэрэглэлтэй эрүүл мэндийг дэмжигч байгууллага 27 байна. Энэ онд шинээр 5 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон.	
<b>2</b>	<b>Зорилт-2: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулна.</b>						
2.1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх	-	Эрт илрүүлгийн хувь	40,5%	42%	Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. -Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40-с дээш насны нийт 27420 буюу хамрагдвал зохих хүн амын 109.7 хувийг эзэлж, өмнөх оноос (57.5) хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь онош батлагдсан байна. -Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2931 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 105.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (79.2) хувиар өссөн. Пап шинжилгээнд нийт 1215 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 16527 эмэгтэй хамрагдаж,	100

						<p>хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 87,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (50,6) хувиар өссөн байна.</p> <p>- Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 887 хүн буюу (54.8) хувь нь хамрагдсан.</p> <p>“Иргэн бүр зүрхээ хайрлая” аяны хүрээнд төрийн болон хувийн хэвшил, анхан шатны байгууллагын 100 эмчийг сургалтад хамруулж, 9 төрлийн контент, шторкыг бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 10 удаагийн давтамжтай нэвтрүүлж, эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсаар давтагдсан тоогоор 161366 иргэнд түгээж ажилласан. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер, зөвлөмжийг 3200 иргэнд, цахимд 131 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 443651 иргэнд хүргэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 24 удаагийн ярилцлагыг иргэдэд хүргэсэн.</p>	
<b>3</b>	<b>Зорилт-3: Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, үйлчлүүлэгчийг нэг дороос бүх төрлийн тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлсэн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлнэ.</b>						
3.1	Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны	-	“Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь	90%	90.5%	Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ болон удирдлага зохион байгуулалтын чиглэлээр тайлант хугацаанд дэмжлэгт хяналтыг 3	90



	гүйцэтгэлд хяналт тавин ажиллах					удаа, зөвлөмж 1, чиглэл 1 хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хэрэгжилт 87,3%-тай байна.	
<b>4</b>	<b>Зорилт-4: Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.</b>						
4.1	БОЭТ-ийн амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах	-	БОЭТ-ийн амбулаторийн 2 давхар өргөтгөл баригдсан байх	-	Өргөтгөл баригдсан байна	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт орон нутгаас 20.0 сая төгрөг батлагдаж зураг төсөв хийгдсэн. -Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ.	100
<b>5</b>	<b>Зорилт-5: Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах үйлчилгээг нэвтрүүлнэ.</b>						
5.1	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо телемедициний техник тоног төхөөрөмжийг сайжруулан цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	-	Алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжийн хангалтын хувь	33%	34%	Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: -БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар тус их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төвийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр байгуулсан. -Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн.	100

						-Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд 4 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж лавлагаа шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан байна	
<b>6</b>	<b>Зорилт-6: Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</b>						
6.1	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ 150,0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	95%	96.2%	Тайлант хугацаанд “Эмч” хөтөлбөрийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлан, 175.0 сая төгрөгийн төсвийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд: -Төгсөлтийн дараах сургалтад 112, ажлын байран дахь сургалтад 2221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. -“UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж нийт 35 эмч оролцлоо. -Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. -Өндөр хөгжилтэй оронд нийт 54 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. -Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр нийт 27 удаагийн соён	100

						<p>гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд 594 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна.</p> <p>-Эрүүл мэндийн салбарын 40 наснаас дээш нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулан 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг эмчлэн, эрүүлжүүлж байна.</p> <p>-Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулагдсан 4 төрөлт спортын наадамд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчид амжилттай оролцон 2 дугаар байр эзэллээ.</p> <p>Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 7.9, нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь 24.4-тай болсон ба тус хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.</p>	
<b>7</b>	<b>Зорилт-7: Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт, баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.</b>						
7.1	Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	160.0 сая	Зохион байгуулагдсан тэмцээний тоо	4	5	<p>Орон нутагтаа улсын аварга шалгаруулах тэмцээн 7, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2 удаа тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 3-аар, оролцсон тамирчдын тоог 498-аар нэмэгдүүлж, 3640 тамирчдыг хамруулан зохион байгуулсан. Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад улсын төсвөөс 275.0 сая , орон нутгийн төсвөөс 152.4 сая төгрөг нийт 427.4 сая төгрөгийг зарцуулж, Орхон аймагт</p>	100

					<p>1300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Улсын аварга шалгаруулах тэмцээнээс дурдвал:</p> <p>- Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг тус тус аймагтаа амжилттай зохион байгуулсан.</p> <p>-Байт харвааны заалны улсын аварга шалгаруулах 15 дахь удаагийн тэмцээнд 24 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд 2 төрөлд нийт 307 тамирчин 57 багц медалийн төлөө өрсөлдсөн.</p> <p>-2023 онд хэрэглэлтэй Пауэрлифтингийн 17 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 30 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд өсвөр, насанд хүрэгчдийн ангилалд нийт 230 тамирчин 148 багц медалийн төлөө өрсөлдсөн.</p> <p>-Авто спортын "SPRINT RALLY" улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 ангилалд 45 тамирчин оролцлоо.</p> <p>-Монгол Улсын Усанд сэлэлтийн 32 дахь удаагийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 27 клубын 378 тамирчид,</p> <p>-Хэт бартаат замын улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрөлд 33 багийн 71 тамирчин тус тус хамрагдсан.</p>
8	Зорилт-8: Хүн амын зорилтот бүлгүүдийн биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.				

8.1	Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшэе" аяныг аймгийн иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх	10,0 сая	Хамрагдагсдын тоо	7000 иргэнийг хамруулсан байна.	8000 иргэнийг хамруулсан байна.	Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшэе" аяны хүрээнд "Нэг анги-Нэг өглөө" өглөөний дасгалын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын 11 сургуулийн 12632 сурагч, 2597 эцэг эх давхардсан тоогоор нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан байна. Мөн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж 8 сургуулийн 506 сурагч, спортын холбоодын багш, дасгалжуулагчид, өсвөрийн шигшээ багийн тамирчид зэрэг 254 иргэнийг хамруулсан. Аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгалын уралдааныг зохион байгуулж 750 гаруй албан хаагчид хамрагдсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл амьдралын дадлыг олгох нөхцөл бүрдсэн.	100
<b>9</b>	<b>Зорилт-9: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж, спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.</b>						
9.1	Биеийн тамир, спортоор хичээллэх заал талбайг нэмэгдүүлэх	-	Жил бүр нэг талбай нэмэгдсэн байна.	33	34	2023 онд шинээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Үйлдвэрчний эвлэлийн хорооны спорт заал ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд төрийн өмчит байгууллагууд болон хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудад нийт 35 спорт заал ашиглагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 3, 16 дугаар	100

						сургуулийн спорт заал, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Сансар худалдааны төвийн хажуу талд спорт заал бүхий цогцолбор тус тус баригдаж байна. Шинээр баригдаж буй спорт заалнууд ашиглалтад орсноор аймгийн 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 2022 онд 0.13м2 байсан бол 2023 онд 0.15м2 болж өмнөх оноос 0.02м2-иар нэмэгдсэн.	
<b>10</b>	<b>Зорилт-10: Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин болон материаллаг баазаар ханган хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.</b>						
10.1	Өвлийн спортын дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	40,0 сая	Хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн н хэрэгжилт 60%-д хүрсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилт 80%	"Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 2023 онд 92.5 хувийн биелэлттэй хэрэгжсэн. Хөтөлбөрийн хүрээнд спортын 7 төрлөөр 10 удаагийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 560 гаруй иргэнийг хамруулсан. Тамирчид тив, улс, бүсийн аварга шалгаруулах 32 тэмцээнд оролцож 280 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Мөн биатлоны Монгол улсын шигшээ багт 5, хоккейн улсын шигшээ багт 14 тамирчин шалгаран тус тус бэлтгэл сургуулилтаа хийж байна. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхэд орон нутгийн төсвийн 220.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цана 17 ширхэг, тэшүүр 14 ширхэг, цас буудагч буу, цасны мотоцикль, усны шланк зэргийг авсан. Швейцарын холбооны улс, Бүгд найрамдах Франц улсын өвлийн спортын үндэсний төвүүдтэй хамтран ажиллаж 200ш хоккейн	100

						<p>тэшүүр, 13 цана хандиваар авч цана, тэшүүрийн тамирчдыг бэлтгэл сургуулилтаа хийхэд хэрэглэл материалаар ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд шинээр 2 мөсөн талбай байгуулж өвлийн спортын мөсний сур харваа, мөсөн шагай, тэшүүр, шорт трекийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хичээллэгсдийн тоо 600-аар, тамирчдын тоо 342-оор тус тус нэмэгдэж нийт 2532 иргэн хичээллэдэг болсон. 2023 онд орон нутагтаа анх удаа Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг нэгэн зэрэг өндөр түвшинд зохион байгуулж 12 аймаг, 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудаас Орхон аймагт нийт 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн байна. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг багийн дүнгээр 2 дугаар байрт шалгарсан.</p>	
<b>11</b>	<b>Зорилт-11: Гэр бүлд суурилсан салбар дундын уялдаа холбоог сайжруулан идэвхэжсэн хандлага оролцоог дэмжинэ.</b>						
11.1	Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	-	Нийт гэр бүлийн 20 хувийг хамруулах	Нийт гэр бүлийн 30 хувийг хамруулна.		Тайлант онд гэр бүлийн боловсрол олгох олон талт үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүнээс "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор өдөрлөг, сургалт, нэвтрүүлэг зэрэг олон талт арга хэмжээг 2 сарын	100

						хугацаанд зохион байгуулсан. "Гэр төсөл"-ийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх газарт 7-30 хоногийн баривчилгаанд байгаа иргэдэд зориулсан хувь хүний сэтгэл зүйн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 7 хоног бүр тогтмол явуулж 528 иргэн хамрагдсан байна. Гэр бүлийн чиглэлээрх сургалт нөлөөллийн ажил өнгөрсөн оноос 13 буюу 23%-иар нэмэгдэж нийт 69 байгууллагын 704 хүнийг хамруулан ажилласан. "Гэр бүлийн харилцаа", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Байгууллагын эцэг эхийн зөвлөл байгуулах" сургалтыг нийт 17 байгууллагын 329 албан хаагчдад, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүд буюу нийт 52 байгууллагын 375 хүнд тус бүр ажлын байран дээр нь зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Дээрх нийт 10 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 9125 өрхийг хамруулсан нь аймгийн нийт өрхийн 32%-ийг эзэлж байна.	
11.2	Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг эхийн зөвлөлөөр	-	Эцэг, эхчүүдийн хамрагдалт 40 хувь	Эцэг, эхчүүдийн хамрагдалт 20 хувь	Эцэг, эхчүүдийн хамрагдалт 40 хувь	Тайлант онд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар, эцэг, эхийн боловсрол олгох зэрэг сэдвээр 8 шторк, 60 постер мэдээлэл, 5 удаагийн лайв мэдээлэл хийж ажиллаж нийт 37000 гаруй хандалт авсан байна. Тухайлбал байгууллагын эцэг эхийн зөвлөлд "Гэрэлт ирээдүйд гар бүү хүр" уриатай хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрөөр 10 удаагийн сургалт,	100



	дамжуулан зохион байгуулах					<p>нөлөөллийн ажлыг зохион байгуулж 219 хүн, "Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд" хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх нь сургалтыг 89 байгууллагын 21500 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулсан. "Харилцаагаа усалж-Хайраар гэрэлтүүлье" өдөрлөгийг 50 гэр бүлийг хамруулан зохион байгуулсан.БШУГ-тай хамтран ЕБС, СӨББ-уудаар дамжуулан нийт эцэг эх асран хамгаалагч нарт бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээг зохион байгуулж 18000 гаруй иргэн хамрагдсан. Нийт 40 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 18000 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамрагдсан нь нийт эцэг эхийн 45 хувь хамрагдсан.</p>	
<b>12</b>	<b>Зорилт-12: Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын үйл ажиллагааг сайжруулна.</b>						
12.1	Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	-	Шийдвэрлэлт-95 хувь	90% шийдвэрлэлт	108 утас, бусад хүсэлт, өргөдөл гомдлын 95%	<p>Тайлант онд 196 хүүхэд хамгааллын дуудлага ирснээс 173 дуудлага буюу 89 хувь нь шийдвэрлэгдсэн, 23 дуудлага буюу 11.7 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэлтийн шатанд байна. Үүнээс хүүхэд хамгааллын дуудлага 97.4 хувь, нийт дуудлагын 87.9 хувь нь гэр бүлийн хүрээнд гарсан дуудлага байна.</p> <p>Хүүхдийн тусламжийн 108 утас"-нд ирсэн дуудлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дуудлагын тоо 5 дуудлагаар буюу 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Тайлант онд хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус</p>	100

						байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхжуулах 7 удаагийн сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажил зэрэг нийт 8 төрлийн 14 арга хэмжээг зохион байгуулсан.	
<b>13</b>	<b>Зорилт-13: Залуучуудад чиглэсэн арга хэмжээ, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний оролцоог дэмжинэ.</b>						
13.1	Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	150.0 сая	Нийт залуучуудын 20 хувийг хамруулсан байх	Хөтөлбөр хэрэгжилт 94 хувь	Хөтөлбөр хэрэгжилт 100 хувь	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 156.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардалд 183.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглэсэн урлаг, спорт, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгэмд эзлэх байр суурь зохих түвшинд дээшилсэн. Мөн тусгай шалгуурын дагуу 8 оюутан сургалтын тэтгэлэгт хамрагдаж, сурч боловсрох, хөгжих боломжоор дэмжин ажилласан байна. Залуучуудын ордонд сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх өрөөг тохижуулж, “Сэтгэл нэмье” төслийг хэрэгжүүлж, нийгэмд эерэг мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 250 гаруй эрчүүдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хүргэсэн. Мөн дартсын Эрчим клуб, Анза дуу бичлэгийн студи, бүжгийн Social	100

						dance клуб, шагай харваа, бийрэн бичиг, 1 амьд хөгжмийн хамтлагийг дэмжин хамтран ажиллаж, 11 сонирхлын клуб үйл ажиллагаа явуулж, бүртгэлтэй 200 гишүүн хамрагдаж байна. Тайлант хугацаанд 134 арга хэмжээнд 17760 залуучуудыг хамруулсан нь аймгийн хэмжээний нийт залуучуудын 59 хувь нь хамрагдсан байна.	
<b>14</b>	<b>Зорилт-14: Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлнэ.</b>						
14.1	“Ач санах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	70.0 сая	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн хувь 60%	Хэрэгжилтийн хувь 80%	2023 онд хөтөлбөрийн хүрээнд: Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Зэвсэгт хүчний 102 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан Хүндэтгэлийн арга хэмжээ, "Эх үрийн элбэрэл" тоглолт, "Ахмадууд дуулж байна" урлагийн наадам, аймгийн аварга шалгаруулах волейбол, шатар, софт воллейбол, ширээний теннисний тэмцээн, сар бүрийн 15-нд ахмадын "Дуулах өдөр" дуун цэнгүүн, ахмад настанд чиглэсэн 4 удаагийн сургалтын үйл ажиллагаа зэрэг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 13600 гаруй ахмад хамрагдсан байна. Орхон аймгийн ХХҮГ, Улаан загалмайн хороо хамтран Жаргалант сумын 78 ахмад, Баян-Өндар сумын 224 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Мөн олон улсын ахмадын өдрийг угтан хэвтрийн өвчтэй 250 ахмадад хүндэтгэл үзүүллээ.	100

						Тайлант оны 9 дүгээр сараас эхлэн ахмад настанд зориулсан алжаал тайлах өрөө, номын сан, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг тохижуулан ажиллуулж өдөрт 30-45 хүн тогтмол үйлчилгээ авч байна. Мөн номын сангийн номын фондыг ахмадууд нэмэгдүүлэн одоогоор 1500 орчим номтой болоод байна. Ахмадын ордонд сэтгэл зүйчийн танхимыг нээн ажиллуулснаар 1 сарын хугацаанд бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг 100 гаруй ахмадад, ганцаарчилсан зөвлөгөөг 19 ахмадад тус тус өгсөн. Тайлант онд хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулбал 3000 ахмадаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Дээрх үйл ажиллагаануудад орон нутгийн төсвөөс 105,0 сая төгрөг зарцуулсан ба хөтөлбөр 80 хувийн хэрэгжилттэй байна.	
14.2	“Анхдагч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	40.0 сая	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн хувь 60%	Хэрэгжилтийн хувь 80%	Хөтөлбөрийн хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 28.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 87 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 127 анхдагчид гэр эргэлт, ахмадын сувилалд 197, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 85 анхдагч тус тус хамрагдсан. Мөн тэмдэглэлт	100

						өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 5, спортын урлагийн 5 төрөлт тэмцээн зэргийг зохион байгуулж 1400 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Тайлант онд нийт анхдагчдын 70 хувь нь хөтөлбөрт хамрагдаж, орон нутгийн төсвөөс нийт 40.0 сая төгрөгийг зарцуулан ажилласнаар тус хөтөлбөр 80 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжиж байна.	
<b>15</b>	<b>Зорилт-15: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ</b>						
15.1	Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх	60,0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилт 60 хувь	Жендерийн хөтөлбөрийн хэрэгжилт 91хувь	Жендерийн хөтөлбөрийн хэрэгжилт 94 хувь	Тайлант онд жендэрийн тухай ойлголт мэдээллийг олон нийтэд сурталчлах зорилгоор "Хөгжилд хамтдаа" жендэрийн мэдлэг олгох сургалт, өдөрлөг "Жендэрт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" нөлөөллийн арга хэмжээ, "Бүх бүлгийн оролцоо тэгш байх тухай ойлголтыг өгөх сургалт", Хуулийн хэрэгжилт цуврал сургалт зэрэг нийт 6 удаагийн сургалт, 2 арга хэмжээ зохион байгуулсан. "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор "Бүх хайраа гэр бүлдээ" өдөрлөг, "Миний үнэ цэнэ миний гэр бүл өглөөний сургалт уулзалт, "Харилцаагаа усалж-Хайраар гэрэлтүүлье" өдөрлөг, "Хүмүүжлийн эерэг арга" сургалт, "Бүх хайраа гэр бүлдээ" сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг, "Жендэрийн сургалт", "Сэтгэл нэмье" гэр бүлийн өдөрлөг зэргийг зохион байгуулж 800 гаруй хүн хамрагдсан. Хэвлэл мэдээллийн байгууллагатай	100

						хамтран "Бүх хайраа гэр бүлдээ" сэдэв дор манлай үлгэр жишээ гэр бүлийг оролцуулсан 4 удаагийн нэвтрүүлэг "Далд хүчирхийллийг ил болгоё" аяны хүрээнд ерөнхий боловсролын 10 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагад зөвлөн туслах, арга зүйгээр хангах зэрэг арга хэмжээг нэг сарын хугацаанд явуулсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэд олон нийтэд хүргэх, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, гэр бүлийн боловсрол олгох мэдлэг мэдээллийг сурталчилж ажилласан. Тайлант хугацаанд 5 төрлийн 16 арга хэмжээнд давхардсан тоогоор 8800 гаруй иргэн хамрагдаж, 12 шторк, 6 нэвтрүүлэг, 220 постер мэдээ, мэдээлэл бэлтгэн мэдээлсэн ба хандалт 283107 байна. Хөтөлбөр 95%-тай хэрэгжсэн.	
16	<b>Зорилт-16: Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах зорилт 100 хувь хэрэгжиж дууссан.</b>						
17	<b>Зорилт-17: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.</b>						
17.1	Орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд	207,2 сая	Мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	350	400	Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 43 иргэнд 51.6 сая, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 482 иргэнийг хамруулж, 94.1 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас тус тус зарцуулан ажилласан.	100

	чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх						
<b>18</b>	<b>Зорилт-18: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</b>						
18.1	Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	ОНТ	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд, ажилд зуучлагдсан иргэдийн тоо	800	1000	Орхон, ХАА-н МСҮТ-үүдтэй хамтран цахилгаанчин, тогооч, барилгын засал чимэглэлч, гагнуурчин, үсчин, оёдолчин зэрэг 7 мэргэжлээр ажил хайгч 95 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн нийт 105 иргэнийг сургаж сургалтын төлбөрт 25.9 сая төгрөг, хоол унааны зардалд 22.0 сая төгрөг тус тус зарцуулсан. Наймдугаар ангийн 329 сурагчид, хорих ангид хүмүүжиж байгаа 40 иргэн, ажил хайгч 31 иргэн нийт 400 иргэнд бүлгийн зөвлөгөө, 250 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, пройфайлинг үйлчилгээг 800 иргэнд, нийт 1450 иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5.0 сая төгрөг зарцуулсан.	100
<b>19</b>	<b>Зорилт-19: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.</b>						
19.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	ОНТ	Байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	1043	1000	Тайлант онд нийт 101 иргэнд 830.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгосон. Үүний үр дүнд 101 ажлын байр хадгалагдаж 59 шинэ ажлын байр бий болсон байна. Залуучуудын Старт-ап арга хэмжээг "Шинэ эхлэл цэг" ТББ-ын сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, 65 залуусыг оролцуулснаас эцсийн	100

						шалгаруулалтаар 1 баг шалгарч 10.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж шинээр 2 ажлын байр нэмэгдсэн. Ажил хайгчаар 1200 иргэн бүртгэгдэж, 1050 иргэн ажилд зуучлагдсан. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд 1100 шинэ ажлын байрыг бүртгэсэн.	
<b>20</b>	<b>Зорилт-20: Аймгийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучилж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажиллана.</b>						
20.1	Ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах					Тайлант онд 42 ажил олгогч байгууллагаас 72 ажлын байранд ажилтан авах захиалга хүлээн авч мэдээллийн сайтуудад байршуулан иргэдэд түгээж байна. Ажил хайгчаар 1956 иргэн бүртгэгдэж, 1050 иргэн ажилд зуучлагдсан байна. Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа 550 иргэнийг нийтийн эзэмшлийн хог цэвэрлэх, шарилж устгах түр ажлын байранд ажиллуулж 110.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Орон нутагт хийгдэх бүтээн байгуулалттай холбоотой тендерийн ажилд оролцох хүсэлтэй 33 ажил олгогч байгууллагаас 408 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллуулсан.	100
<b>21</b>	<b>Зорилт-21: Бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх, урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.</b>						
21.1	"Багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бүх шатны	140.0 сая	Тухайн жилд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн	90 хувь	100 хувь	"Багш" хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 21 үйл ажиллагаа төлөвлөн батлуулж,	90



	<p>боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих</p>		<p>ажлын гүйцэтгэлийн хувь</p>			<p>хэрэгжилтийг хангаж байна. Хөтөлбөрийн хүрээнд ЭЕШ-ын чанарыг сайжруулах чиглэлээр төгсөх ангийн сурагчдын ЭЕШ-ын урьдчилсан 2 удаагийн сорил, аймгийн мэргэжлийн зэрэгтэй багш нарыг түшиглэн залуу багш нарын арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг хангах "Ментор багш" төсөл, 2,3,4 болон 6,7,8,9 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан модуль сургалт, аймгийн "Зөвлөх баг"-тай хамтарсан багшийн арга зүйг оношлох, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа, "Боловсролын шинэ сэргэлт-Сургуулийн менежмент " сэдэвт багш удирдах ажилтны сургалт, хэлэлцүүлэг, багш нарын "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-ийг дэмжсэн үйл ажиллагаа, "Ур чадварын уралдаан", "Чадварлаг багш" үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Мөн аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш, ажилтнуудыг Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамруулах болон 4, 14 дүгээр сургуулийн 4 багш, ажилтныг Япон, Герман, Солонгос улсад богино хугацааны сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд хамруулахад тус тус дэмжлэг үзүүлсэн байна. Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр тус хөтөлбөр 90 хувийн хэрэгжилттэй байна.</p>	
--	--	--	--------------------------------	--	--	--	--

22	<b>Зорилт-22: Эрдэнэтийн өв соёлыг хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, соёл урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжиж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.</b>						
22.1	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	20.0 сая төгрөг	Мэргэжил дээшлүүлсэн уран бүтээлчийн тоо	Соёл, урлагийн салбарын 100 ажилтан, албан хаагч	Давхардсан тоогоор 360 ажилтан албан хаагч	2023 онд соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах тухай", "Гамшгийн бэлэн байдал", "Хэрэглээний англи хэл", "Авлигын эсрэг хууль", Жендэрийн тэгш байдал, "Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого", "Гэр бүлийн үнэ цэнэ", аймгийн Цагдаагийн газартай хамтарсан "Анзаар", "Соёлын өвийг хамгаалах нь" сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 346 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд соёл, урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхэд, залуучуудын театрын 14 уран бүтээлчийг мэргэжлийн нүүр хувиргалтын 2 өдрийн сургалтад хамруулсан. Аймгийн Музейгээс Үндэсний музейтэй хамтран төвийн бүсийн музейн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Музейн үзмэр дэглэлт, хадгалалт, хамгаалалт", "Музейн үзмэр тайлбарлах арга зүй", "Музейн боловсролын хөтөлбөр" сэдэвт сургалтуудад аймгийн Музейн 9, Соёлын төвүүдийн орон нутаг судлах танхимын 5 ажилтан тус тус хамрагдсан. Мөн "Соёлыг түгээе" аяны хүрээнд "Эрдэнэт	90

						үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбороос аймгийн соёлын төвүүдийн бүжгийн багш, дууны багш, хөгжмийн багш, техникийн ажилчид, номын санчдад соёлын ажлын арга зүй, онол практик хосолсон 5 өдрийн сургалтыг зохион байгуулж 30 ажилтан хамрагдсан байна.	
22.2	Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Соёл, урлагийн байгууллагууд техник хэрэгслээр хангагдсан байх	4 байгууллага	4 байгууллага	2023 онд аймгийн Нийтийн номын санд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад 55.6 сая, "Аялгуу", "Хэмнэл" соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 134.4 сая, аймгийн Музейд виртуал төхөөрөмж авахад 19.4 сая, Жаргалант сумын Соёл мэдээллийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, техник, хэрэгсэл авахад 93.4 сая, тус төвд их засвар хийхэд 206.6 сая нийт 509.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа.	100
<b>23</b>	<b>Зорилт-23: Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах хамгаалах, сурталчлах ажлын чанарыг нэмэгдүүлэн, иргэд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.</b>						
23.1	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн хяналт оролцоог сайжруулах	4.0 сая	Гэрээгээр хамгаалах ажлыг үргэлжлүүлсэн байна.	20 өрхтэй гэрээ байгуулсан	20 өрхтэй гэрээг сунгах	2022 оноос эхлэн гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд дээрх өрхүүдтэй гэрээг сунгаж харьяалах нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх 28 дурсгалт газрын 343 булш, оршуулгын дурсгалын	100

						аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын А/691 дүгээр захирамжаар нийт 4.0 сая төгрөгийн урамшууллыг 20 өрхөд олголоо.	
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ИРГЭД, БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИД ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ							
1	<b>Зорилт-1: “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг шуурхай авдаг болгох, иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хянадаг тогтолцоог сайжруулна.</b>						
1.1	“Цахим-Эрдэнэт-1” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	УТ, ОНТ	Хэрэгжилтийн хувь	Хөтөлбөр батлагдсан	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	Аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас одоогийн байдлаар 10 арга хэмжээ буюу 58.9 хувь нь бүрэн хэрэгжиж дууссан байна. Үүнд: Смарт Эрдэнэт платформ, аймаг болон сумдын веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн түргэний үйлчилгээнд ухаалаг таблет, багийн төвүүдэд ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, Цахим Эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо, гадаад гарц, мэдээллийн аудит, дугаар илрүүлэгчтэй камер байна. Санхүүжилтэд 1.37 тэрбум төгрөг зарцуулсан ба үүний 62.5 хувь нь программ хангамж, 25.5 хувь нь тоног төхөөрөмж, 12 хувь нь ажил үйлчилгээний төлбөр байна. Төслийн нэгж, мэдээлэл	100

						сурталчилгаа, Ухаалаг байгууллага аян өрнүүлэх гэсэн 3 арга хэмжээ үргэлжлэн бизнес хөгжүүлэлт хийгдэж байгаа ба 2023 онд тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд 227.0 сая төгрөг зарцууллаа.	
1.2	Иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг цахимаар авдаг болгох, өргөдөл гомдлыг цахимаар хянадаг ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	УТ, ОНТ	Үйлчлүүлсэн иргэдийн тоо	607 иргэн, байгууллага үйлчилгээг цахимаар авсан	5000-аас дээш иргэн	Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хоёр сумандаа E-Mongolia төвийг байгуулан үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэн ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшээд байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар нь дэргэдээ 24 цагийн үйлчилгээ бүхий "Цахим төв"-ийг нээн ажиллуулж байна. Уг төвөөр төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаар иргэн хуулийн этгээдийн 16 төрлийн 37 үйлчилгээ, E-Mongolia Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс иргэн, хуулийн этгээдийн 73 төрлийн үйлчилгээг, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаар 9 төрлийн 72 үйлчилгээг тус тус үзүүлж байна. ХААН банкны АТМ болон киоск машин, Төрийн банкны АТМ, төлбөр тооцооны киоск машинаар төрийн үйлчилгээ, үүрэн холбоо, авто тээвэр гэх мэт 5 төрлийн 33 үйлчилгээг цахимаар хүргэн иргэдэд үйлчилж байна. Одоогийн байдлаар Цахим төвөөр нийт 7500 гаруй иргэн үйлчлүүлж, цахим үйлчилгээ авсан байна.	100

2	<b>Зорилт-2: Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна</b>						
2.1	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай болгох зорилгоор Е-Монголиа төвийн үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах	Орон нутгийн төсөв	Төрийн үйлчилгээний Е-Монголиа төв үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх	33 байгууллага Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан байна.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, цахим үйлчилгээний тоо нэмэгдэнэ. Төрийн үйлчилгээнд операторын үйлчилгээ нэвтэрнэ	Баян-Өндөр, Жаргалант сумын E-mongolia /ХурДан/ төв иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү төвийн үйл ажиллагаа нь төрийн үйлчилгээг цахимаар авахад шаардлагатай мэдээлэл, арга зүйн зөвлөгөөг иргэдэд өгөх, E-mongolia аппликейшн гар утсандаа татах, E-mongolia порталаас хэрхэн төрийн үйлчилгээг өөрсдөө авах арга зүйн зөвлөгөөг өгч, төрийн мэдээллийн Хур системийг ашиглан иргэд, байгууллагуудад төрийн байгууллагын 236 төрлийн лавлагаа тодорхойлолтуудыг гарган өгч үйлчилгээ үзүүлж байна. Цахимжилт хэрхэн явагдаж байгаа талаар танилцуулга уулзалтыг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дунд зохион байгуулж Хөдөлмөр халамжийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Татварын хэлтсээс үзүүлж буй үйлчилгээнүүдийг хэрхэн цахимжуулах талаар туршлага солилцсон. Мөн E gazar.gov.mn цахим систем ашиглалтад орсноор газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас үзүүлдэг 76 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. 2023 онд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр нийт	100

						113 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 41883 ширхэг лавлагаа тодорхойлолт, тусгай зөвшөөрөл зэргийг гаргаж иргэдэд Тараах материал гарын авлага тогтмол өгч ажиллаж байна. Төлбөртэй лавлагаа, тодорхойлолт гарган тухайн байгууллагуудын дансанд нийт 99.2 сая төгрөгийн орлого оруулсан дүнтэй байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 80-90 хувьд И-Монголиа аппликейшн суулгаж, бүртгэл үүсгэж, төвийн <u>70351000</u> , <u>70396000</u> лавлах дугаарт ирсэн дуудлага бүрд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна	
2.2	Олон нийтэд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	АЗДТГ-ын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай сурталчилна	Аймаг, орон нутгийн телевиз, радио, сонин, сайт, студитай хамтран ажилласан	Төрийн үйлчилгээ, орон нутгийн хийсэн ажлын талаарх мэдээлэл иргэдэд шуурхай хүрсэн байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны сайт болох ERDENET.MN, аймгийн Засаг даргын пэйж хуудас, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудас, Орхон аймгийн онцгой комисс пэйж хуудсуудыг Мэдээллийн төвөөс хөтлөн явуулж байна. Дээрх сайт болон пэйж хуудсуудад олон нийтэд хамааралтай, цаг үеийн болон үйл явдлын мэдээ мэдээллийг видео, фото, текстэн хэлбэрээр хүргэхийн зэрэгцээ, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээлэл, захирамж, уриалга, баннер, постеруудыг цаг тухай бүрт бэлтгэн олон нийтэд хүргэн ажиллалаа. Мөн орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын	100

						<p>ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ болон, бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг сурталчлан ажиллав.</p> <p>Орон нутагтаа зохион байгуулсан 10 орчим улс бүсийн чанартай тэмцээн уралдааныг олон нийтэд сурталчлан, фото зураг, видео, текстэн мэдээ, сурвалжилга бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Улаанбаатар хотын <a href="http://www.zarig.mn">www.zarig.mn</a>, <a href="http://www.gogo.mn">www.gogo.mn</a>, <a href="http://www.gereg.mn">www.gereg.mn</a> вэб сайтаар, цаг үеийн онцлог үйл явдал, аймаг орон нутгийн бодлого шийдвэрийн талаарх мэдээ мэдээллийг Монголын Үндэсний олон нийтийн телевизээр түгээж ажилласан.</p> <p>Цахим хуудасны хандалтыг нэмэгдүүлэхийн тулд фэйсбүүк сүлжээ, группуудад шэйр хийж олон нийтийн хандалтыг авч ажилласнаар дагагчдын тоо 14,520 болж нэмэгдэн, нийтлэлийн сарын хүртээмж 129,610 -156,780 хүрсэн байна.</p>	
2.3	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу эрхлэн хөтлөх	ОНТ	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж албан хэргийг	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж албан	Архивын баримт бичгүүд хууль тогтоомжийн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Монгол хэлний зөв	100



			хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавина.	хэргийг хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавина.	дагуу хадгалагдана. Тамгын газрын дотоод хэргийн эрхлэлтэд ахиц гарна.	бичих дүрмийн журмалсан толь, 2021 оны Баримт бичгийн стандарт /MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021/-ын дагуу аймгийн ЗДТГ-ын албан хэргийг хөтөлж байна. 2023 оны жилийн эцсийн жилийн байдлаар 4025 ирсэн бичгийг И-Оффис программд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавьж, 2600 явсан бичгийг стандартын дагуу хэвлэн 8451 байгууллагуудад цахимаар болон цаасаар хүргүүлсэн.	
2.4	Иргэд, олон нийттэй харилцах, иргэдийн санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэх	-	Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байх	Холбогдох хууль тогтоомжийг мөрдсөн	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн.	2023 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 10140 өргөдөл, гомдол ирсний 85 буюу 0.8 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 10055 буюу 99.2 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 157 нь гомдол, 284 нь талархал, 115 нь санал, 1 нь мэдэгдэл, 9583 нь хүсэлт байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах”- 70353511 дугаарын утсыг аймгийн захиргааны байранд ажиллуулан тус төвд биечлэн, <a href="http://www.irgen.erdenet.mn">www.irgen.erdenet.mn</a> цахимаар болон утсаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна. Тайлангийн хугацаанд тус төвд нийт 4026 өргөдөл, гомдол ирснээс 4001 нь буюу 99.4 хувь нь хуулинд заасан	100

						хугацаанд шийдвэрлэгдсэн, 25 нь буюу 0.6 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд газрын харилцаатай холбогдолтой асуудлаар 16.1 хувь, нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 6.4 хувь, нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 5.6 хувь, барилгын асуудлаар 4.8 хувь, халаалт, цэвэр бохир устай холбогдолтой асуудлаар 8.6 хувь, цахилгаан шугам сүлжээ, гэрэлтүүлэгтэй холбогдолтой асуудлаар 5.2 хувь, авто зам, гүүр, зам засварлах асуудлаар 3.3 хувь, нийтийн тээврийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 3.6 хувь, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.5 хувь, худалдаа, үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.4 хувь эдгээр өргөдлүүд нийт өргөдлийн 58.5 хувийг эзэлж байна	
2.5	Мэдээллийн технологийг сайжруулах, цахимжуулах, Тамгын газрын	Орон нутгийн төсөв	Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах	Мэдээллийн санд хандах, мэдээлэл олж авах цаг хугацаанд	Сүлжээний хэвийн ажиллагааны найдвартай	Нутгийн удирдлагын ордон, Захиргааны IV байрны Архивын тасаг, E-mongolia төв, нэг цонхны интернэт, дотоод сүлжээг шинэчилж, хуучирч илжирсэн	100

	сүлжээний хэвийн ажиллагааг хангах			хэмнэлт гарсан	байдал дээшилнэ.	кабелуудыг сольсон. Нутгийн удирдлагын ордны давхар бүрд сүлжээний зориулалтын хайрцаг суурилуулж cisco managed свитчүүд тавьсан ба ингэснээр сүлжээг ангилах, байнгын хянах боломжтой болсон. Мөн дотоод сүлжээний хурд 10/100mb/sec-ээс 10/100/1000mb/sec болж 10 дахин нэмэгдсэн.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.</b>						
3.1	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах, лавлагаа өгөх, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх, хадгалах, ашиглуулах болон төрийн архивт шилжүүлэх	Орон нутгийн төсөв	Тамгын газрын албан хэргийг Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтлөх	Холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн	Тамгын газрын дотоод хэргийн эрхлэлтэд ахиц гарна.	2023 оны жилийн эцсийн байдлаар 4025 ирсэн бичгийг И-Оффис программд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавив. 2600 явсан бичгийг стандартын дагуу хэвлэн 8451 байгууллагуудад цахимаар болон цаасаар хүргүүлэв. Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган танилцуулж, хугацаатай ирсэн 159 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Аймгийн ЗДТГ-ын Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх хадгаламжийн нэгжийн жагсаалтын дагуу 2011-2016 он хүртэлх баримтуудыг холбогдох журам, заавар, стандартад нийцүүлэн цахимжуулаад байна.	100
<b>4</b>	<b>Зорилт-4: Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, иргэдэд архивын баримтын лавлагаа мэдээллээр шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</b>						
4.1	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд архивын баримтыг	Орон нутгийн төсөв	Архивын баримтын цахимжуулалтын хувь	Цахимжуулалтын хувь 35%	Цахимжуулалтын хувь 60%	"Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	100

	цахимжуулах ажлыг эрчимжүүлэх					ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 31.9 сая төгрөгийг тусган батлуулснаар нийт 4 гэрээт ажилтан архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд 13 хөмрөгийн 26 дансны 1100 хадгаламжийн нэгжийн 86560 хуудас баримтыг нягтлан шалгаж, скайнарадаж, цахим хувь үүсгэсэн. Үүнээс 13 хөмрөгийн 26 дансны 711 хадгаламжийн нэгжийн 70973 хуудасны 133758 хүний нэр, 20640 байгууллагын нэр, 26507 газар зүйн нэр, 62280 заалтыг архивын AMS болон E-DOC программд шивж цахим холболт хийн мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашигласнаар иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна. E-DOCUMENT программд малын А дансыг нягтлан шалгаж, цахим холболтыг хийж, малын А данс бүрэн цахимжсан.	
4.2	Иргэдэд архивын баримтын лавлагаа мэдээллээр шуурхай үйлчлэх	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу үйлчлэх	Холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн	Холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн	Орон нутгийн төсвийн 26.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн төхөөрөмж болон 14900 ширхэг соронзон чип, 5.0 сая төгрөгөөр баримтыг сэргээн засахад шаардлагатай тоног төхөөрөмж, худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төрийн архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад 69 м.кв хадгаламжийн сангийн өрөөг	100

						<p>шинээр тохижуулан 220.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник хэрэгслээр хангаж сан хөмрөгийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлсэн. Мөн 6 иж бүрэн компьютероор хангаж, баримтыг цахимжуулах болон лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний хүрээнд:</p> <p>Лавлагаа, хуулбар олгох, баримтыг ашиглуулах хүсэлтийн дагуу нийт 1037 иргэн, хуулийн этгээдэд архивын баримтын лавлагаа гаргах үйлчилгээг үзүүлсэн байна. E-archives.gov.mn сайт болон онлайнаар ирүүлсэн хүсэлтийн дагуу лавлагааг цаг тухайд нь шийдвэрлэж, бусад аймаг хот руу захиалга өгсөн 760 иргэний лавлагааг тухай бүрд нь иргэнд хүлээлгэн өгсөн.</p>	
<b>5</b>	<b>Зорилт-5: Төрийн байгууллагуудын И-Оффис системийг сайжруулна.</b>						
5.1	Төрийн байгууллагуудын И-Оффис системийн хөгжүүлэлтийг сайжруулах	орон нутгийн төсөв	Төрийн байгууллагууд И-Оффис системийг бүрэн эзэмшсэн байна.	20%	50%	<p>Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд И-Оффис систем ашиглагдаж байна. Улсын хэмжээнд Засгийн газрын хэрэг Эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын <a href="https://docx.gov.mn/">https://docx.gov.mn/</a> системд интеграци хийж албан бичиг солилцох хөгжүүлэлт бүрэн хийгдэж ашиглалтад орсноор тус системд холбогдсон 1374 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдээд байна. Системийг</p>	100

						154 байгууллагын 1675 хэрэглэгч буюу 80% нь албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. И-оффис системийн ашиглалтыг өмнөх онтой харьцуулахад байгууллага 13.0 хувь, хэрэглэгч 17.0 хувиар тус тус өссөн байна.	
<b>6</b>	<b>Зорилт-6: Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</b>						
6.1	“Багийн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Улсын болон орон нутгийн төсөв	Хөтөлбөрийн зорилтууд биелсэн байна.	90%-тай хэрэгжсэн	Хэрэгжилт 100%	<p>“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2023 онд 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын Зэст багийн цогцолбор төвийн барилгыг ашиглалтад хүлээн авлаа.</li> </ul> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар багийн зарим байруудад урсгал засварын ажлуудыг хийх, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор эд хогшил, тоног төхөөрөмжөөр хангах, “Иргэний цахим булан”-г байгуулах, иргэдэд төр засгийн бодлого, нутгийн хурал, захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, бусад мэдээллийг хүргэх зорилгоор 29 багийн иргэдийн дунд хэлэлцүүлэг, баг сурталчлах өдөрлөгүүдийг зохион байгуулав.</p> <p>Мөн багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудад давхардсан тоогоор</p>	100

						710 албан хаагчдыг хамруулж, багийн ИНХ-ын Ажлын алба болон хөршийн холбоод, хэсгийн ахлагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллалаа. 2023 оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн.	
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ</b>							
<b>1</b>	<b>Зорилт-1: Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, хариуцлагыг чангатгана.</b>						
1.1	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	-	Ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож үнэлнэ.	70%	90%	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг тайлант оны эхний хагас жил Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу үнэлж дүгнэсэн ба 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал” шинэчлэн батлагдсантай холбогдуулж Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн биелэлтийг шинэчилсэн журмын дагуу 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор үнэлгээний баг томилогдон үнэлсэн. Үнэлгээг хийхдээ ёс зүй, хариуцлагыг шалгуур үзүүлэлт болгон үнэлсэн. Тайлант онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100

2	<b>Зорилт-2: Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.</b>						
2.1	Хүний нөөцийн программ цалингийн нэгдсэн системтэй холбогдсонтой уялдуулж орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хяналтыг сайжруулах	Орон нутгийн төсөв	Хэрэгжилт хувиар	90%	100%	“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд байгууллагын бүтэц, орон тооны дагуу албан хаагчдын бүртгэлийг бүрэн хийсэн. Тус системд албан хаагчийн үндсэн мэдээлэл, улс болон төрд ажилласан жил, цалин хөлсний өөрчлөлтийг нэмэлтээр мэдээлэн ажиллаж байна. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн тогтолцоо цахим системтэй цалингийн нэгдсэн систем холбогдсоноор цалин хөлсний зардлыг шууд хянах боломжтой болсон.	100
3	<b>Зорилт-3: Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана., хэрэгжилт, хяналтыг сайжруулна.</b>						
3.1	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг тухайн байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана.	90%	100%	Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөнд 3 зорилт 11 арга хэмжээ тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд байгууллагын орчин болон албан хаагчдын ажиллах нөхцөл, хэрэглээнд зориулж 19 нэр төрлийн тавилга эд хогшилд 331,291, 897 (гурван зуун гучин нэгэн сая хоёр зуун ерэн нэгэн мянга найман зуун ерэн долоо) төгрөг, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад 2023 оны байдлаар 50 нэр төрлийн 166, 293, 415 (нэг зуун жаран зургаан мянга хоёр зуун ерэн гурван мянга дөрвөн зуун арван тав) төгрөгийн тоног	100



						төхөөрөмж, 48 албан хаагч томилолтоор ажиллаж, томилолтын зардалд 39,428,800 (гучин есөн сая дөрвөн зуун хорин найман мянга найман зуу) төгрөгийг зарцуулсан.	
3.2	Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	Улсын болон орон нутгийн төсөв		90%	100%	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын 2023 оны төлөвлөгөөнд 2 зорилт, 11 арга хэмжээ тусгагдсан. Төлөвлөгөөний биелэлтэд тайлант оны байдлаар үнэлгээ хийхэд 99.0 хувийн хэрэгжилттэй байна. Хүрсэн түвшин: - ахлах түшмэлийн сургалтад 3 албан хаагч; - мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч; - богино хугацааны сургалтад 1 албан хаагч; - Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 хөтөлбөрт байгууллагын албан хаагчид оролцож “Хувь хүний хөгжил”-д чиглэсэн төлөвлөгөөт сургалтуудыг авч байна. Тайлант онд: -Шинэ зууны манлайллын хэв маягууд -Стрессийг зохицуулахад таны оролцоо -Амжилтад хүрэх хүсэл -Аз жаргалтай ажлын байр-Стресс менежмент -Төрийн албан хаагч ба дипломат ёс -Аз жаргалтай ажилтан сэдэвт сургалтад хамрагдсан. Тус сургалтуудад давхардсан тоогоор 100 албан хаагч оролцуулсан.	100

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХЭЛТЭС, АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЯЛДУУЛАХ, ЗАСАГ ДАРГЫГ УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГАТАЙ ЗӨВЛӨГӨӨ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХАНГАХ ЗАМААР ЗАСАГ ДАРГААС ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ**

<b>1</b>	<b>Зорилт-1: Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын талаар болон Тамгын газрын хэлтэс, албад, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах</b>						
1.1	Аймгийн ИТХ, Засаг даргыг захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөгөө, дэмжлэгээр хангаж, үйл ажиллагааны явц байдалд хяналт тавих	-	Холбогдох хууль тогтоомж, Төрийн албаны стандарт мөрдөгдөж байх	Захиргааны удирдлагаар хангаж ажилласан.	ажилд тодорхой ахиц гарна.	Хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаан, Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан ба холбогдох мэдээллээр тухай бүр ханган ажиллахын зэрэгцээ нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөгөө, дэмжлэгээр хангаж, үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавьж ажилласан.	100
1.2	Тамгын газрын дотоод ажлыг эрхлэн гүйцэтгэх	-	Холбогдох дүрэм зааврын хэрэгжилтээр	Холбогдох хууль дүрэм, шагналын журмыг мөрдөж ажилласан	Холбогдох хууль дүрэм, шагналын журмыг мөрдөж ажиллах	Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнийг 51 удаа зохион байгуулж холбогдох байгууллагуудад нийт 398 гаруй үүрэг даалгавар өгөгдсөн байна. Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, нийт 25 удаагийн хурлаар 102 асуудлыг хэлэлцэж, уг асуудлуудтай холбогдуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгавар өгч ажиллалаа. Аймгийн Засаг даргын захирамжийг 1032 захирамжийг бүртгэж, хөрөнгө санхүүтэй холбоотой 700 гаруй	100

						захирамжуудыг холбогдох хуулийн дагуу Шилэн дансанд хугацаанд нь байршуулан ажиллаж байна. Төрийн дээд цол, одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн 450 гаруй иргэдийн материалыг судалж, холбогдох дээд шатны байгууллагад нь уламжлан, 290 гаруй иргэнийг Орхон аймгийн Хүндэт тэмдгээр, 1260 иргэнийг аймгийн Засаг даргын Жуух бичиг, бусад шагналаар шагнасан байна.	
<b>2</b>	<b>Зорилт-2: Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт, шинжилгээ үнэлгээ хийх</b>						
2.1	Бодлогын баримт бичгүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ нь стандартын шаардлага хангасан, бодитой байх	-	Тайлан мэдээ, үнэлгээний бодит байдал сайжирна.	Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Орхон аймаг, Эрдэнэт хотыг хөгжүүлэх “Ногоон тогтвортой хөгжил-2025”, Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.	100

2.2	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн орон нутагтай холбоотой заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Улсын болон орон нутгийн төсөв	Хэрэгжилтийг тооцож ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байх	Засаг даргын зөвлөл, АИТХ-аар хэлэлцүүлж, хангалттай үнэлэгдсэн.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн аймагт холбогдох арга хэмжээ бүрэн биелнэ.	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн хэрэгжилт 91.7 хувь, хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 94.3 хувь, аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 90.1 хувь, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө 90.9 хувьтай тус тус хэрэгжсэн байна.	90
2.3	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг тооцох	Улсын болон орон нутгийн төсөв	Биелэлтийг хугацаанд нь тооцож, Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн байх	Засаг даргын зөвлөл, АИТХ-аар хэлэлцүүлж, хангалттай үнэлэгдсэн.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдана	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, 2023 оны байдлаар биелэлтийг гарган аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 91.1 хувийн хэрэгжилттэйгээр үнэлүүллээ.	91.1
2.4	Захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Орон нутгийн төсөв	Байгууллага, ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг бодитой, үнэн зөв үнэлж дүгнэсэн байх.	-	Санал зөвлөмж, шийдвэрийн төсөл боловсруулж, биелэлтийг нь хангуулна.	Аймгийн хэмжээнд захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн засаг даргын захирамжаар байгуулан Засаг даргын дэргэдэх 25 агентлаг, 2 сумын ЗДТГ-ын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион	100

						байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үйл ажиллагааны үр дүн, үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагыг /Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар/ шилдгээр шалгаруулан аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар баталсан журмын дагуу тус бүр 3.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. ХШҮ-ний дүнд үндэслэн агентлагууд болон сумдын ЗДТГ-т цаашид анхаарч ажиллах, ажлаа эрчимжүүлэх талаарх зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг, чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
2.5	Монгол Улсын Ерөнхий сайд, шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламж болон бусад сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах	УТ, ОНТ	Биелэлтийг тооцож хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байх	Гэрээний биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.	2023 онд гэрээ байгуулах, биелэлтийг тооцож ЗГХЭГ болон холбогдох яамдад хүргүүлсэн байна.	Монгол Улсын сайд, Шадар сайд болон яамдын сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд хэрэгжилтийг тооцон яамдууд болон ажлын албадуудад хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг тооцон үзэхэд 90-99.2 хувийн үнэлгээтэйгээр үнэлэгдсэн байна. Жил бүр аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, газрын дарга нартай байгуулдаг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан арга	100

						хэмжээнүүдийг төлөвлөн ажилласнаар хамтран ажиллах гэрээний хэрэгжилт үр дүнтэй байна.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог нэмэгдүүлэх</b>						
3.1	Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулан ажиллах	-	Гэрээний хэрэгжилтийн хувиар	76%	90%	Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 81 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийн биелэлт 79.8 хувьтай хэрэгжиж байна.	88.6
3.2	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах	Орон нутгийн төсөв	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ бүтээлч, үр дүнтэй байх	14 ТББ 60.0 сая төгрөг	ТББ-ын тоог нэмэгдүүлэх	2023 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай гэрээ байгуулахад 80.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс, нэгжээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 ТББ-тай гэрээ байгуулж 79.1 сая төгрөг зарцуулаад байна. Чиг үүргийн хувьд хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хоршоо хөгжүүлэх, байгаль экологийн, хүнсний аюулгүй байдал, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг, үнийн асуудал зэрэг 14 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж байна	100
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ЗАСАГ ДАРГА БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ							
<b>1</b>	<b>Зорилт-1: Хууль эрх зүйн удирдлага, зохицуулалтаар хангах</b>						

1.1	Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэх	-	Шүүхэд төлөөлсөн хэргийн тоо	16	Гүйцэтгэлээр	Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ыг төлөөлөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тогтмол оролцож байна. Тайлант хугацаанд нийт 28 хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаагаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын нэхэмжлэлтэй 7 хэрэг байна. Нийт хэргээс 10 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. Ажиллагаанд байгаа үлдэгдэл 18 хэргүүдийг төрлөөр нь авч үзвэл: Иргэний хэрэг – 6, Захиргааны хэрэг – 10, Эрүүгийн хэрэг 2 тус тус байна.	100
1.2	Эрх зүйн сургалт, сурталчилгааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	20.0	Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	107500	Тоог нэмэгдүүлэх	Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 4 цэгт /Баян-өндөр суманд 3, Жаргалант суманд 1/ Эрх зүйн хөтчийн булан, Ерөнхий боловсролын 13-р сургууль, 15-р сургууль дээр “Сурагчдын эрх зүйн хөтчийн булан”-г тус тус байгуулж иргэд хууль зүйн туслалцаа мэдээлэл авахад шаардлагатай, техник тоног төхөөрөмж, гарын авлагаар бүрэн хангаж, эдгээр буланг эрх зүйн хөтөч нар хариуцан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл, туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Эрх зүйн хөтөч нар тайлант хугацаанд 12 сэдвээр 22 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1176 иргэн хамрагдаж, 366 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 86 зурагт хуудас, гарын авлага, постер, номын эх	100

						бэлтгэн иргэдэд тарааж, “Номин” телевизтэй хамтран “Хуулийн цаг” 30 удаагийн нэвтрүүлэг, богино хэмжээний видео 10, нийт 40 нэвтрүүлэг, видео бэлтгэж телевиз болон цахим хэлбэрээр иргэдэд сурталчилж ажилласан. Хууль, эрх зүй хүний эрхийн ойлголт мэдлэг олгох аймгийн аварга шалгаруулах мэтгэлцээний тэмцээн зохион байгуулж 14 сургуулийн 96 сурагчийг хамруулсан. Сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 123386 хүн хамрагдсан байна.	
1.3	Хүний эрхийг хангах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	5.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	100	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2023 онд батлагдсан "Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам"-ын дагуу Хүний эрхийн төлөв байдлын тайланг 4 бүлэг, 9 арга хэмжээний хүрээнд нэгтгэн гаргаж хугацаанд нь хүргүүлсэн. Мөн ХЭҮК-оос ирүүлсэн 3 зөвлөмж, 1 албан шаардлагыг биелүүлж, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Хуулийн байгууллагуудын хамтарсан нээлттэй хаалганы өдөрлөг, ЕБС-ын сурагчдад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, үе тэнгийн дээрэлхэлттэй холбогдсон сургалт, Хорих ангид ял эдэлж байгаа иргэдийн эрхийг хамгаалах шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх зэрэг нийт 4 арга хэмжээг зохион байгуулсан. Хүний Эрхийн	100



					<p>түгээмэл тунхаглалын түүхэн 75 жилийн ойг тохиолдуулан 2023 оны хичээлийн шинэ жилийн эхний өдөр ерөнхий боловсролын 22 сургуулийн сурагчдад хүний эрхийн түгээмэл тунхаглалыг таниулах сургалт зохион байгуулсан.</p> <p>Жаргалант суманд Хүний эрхийн үндэсний комиссын Орхон аймаг дахь ажилтантай хамтран хүний эрх, хүний эрхэд суурилсан хандлага, ажлын байрны бэлгийн дарамт, үе тэнгийн дээрэлхэлт сэдвээр сумын 40 төрийн албан хаагч, иргэд, сурагч нарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн нийт 22 албан хаагч болон Цагдаагийн газрын 62 албан хаагч нарт хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа хүний суурь эрх, арга зүйг хэрэгжүүлж чадавхыг төлөвшүүлэх, тэр дундаа хоригдсон, баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох харьцах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүний эрхийн Үндсэн ойлголт” сэдвийн хүрээнд, Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн хугацаат цэргийн албан хаагч нарт болон тус ангийн бие бүрэлдэхүүн нийт 50 хүнд “Хүний эрхийн үндсэн ойлголт ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдвийн хүрээнд тус тус сургалт зохион байгуулсан. Мөн ХЭҮК-ын гишүүд Орхон аймагт ажиллах үеэр төрийн байгууллагын</p>	
--	--	--	--	--	--	--

						албан хаагч нарт 3 удаагийн сургалт хийж, 130 албан хаагч хамрагдсан.	
1.4	Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд төлөвлөж зохион байгуулах, тайлагнах	5.0 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94	96	<p>Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгүүдэд авлигын эрсдэлийг бууруулах, төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах, худалдан авах ажиллагааны болон төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн сахилга батыг дээшлүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.</p> <p>Мөн “Аймгийн хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн ба хэрэгжилтийг тооцон төлөвлөгөөний биелэлт, хэрэгжүүлсэн ажлын тайланг АТГ-т тогтоосон хугацаанд хүргүүлж, <a href="http://www.erdenet.mn">www.erdenet.mn</a> сайтад байршуулж тайлагнаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 9 байгууллагад явуулж нийт 218 албан хаагч хамрагдсан.</p> <p>АТГ-т иргэдээс ирүүлсэн 5 өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх</p>	100

						ажиллагаанд ирүүлсэн чиглэлийн дагуу оролцож тайлагнаж ажилласан.	
1.5	Хууль тогтоомжийн лавлагааны сан бүрдүүлж, иргэд байгууллагад лавлагаа мэдээллээр үйлчлэх	-	- Санд шинээр бүртгэсэн актын тоо -Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	-1030  -120	Нэмэгдүүлэх	Хууль тогтоомжийн лавлагааны санд нийт 51526 хууль тогтоомжийн актыг гар болон цахим сандаа бүртгэн авч, “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем” болон “Төрийн мэдээлэл”, ”Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл” сэтгүүл, гар санг ашиглан иргэд, байгууллагад мэдээлэл, лавлагаагаар үйлчилж байна. Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын нийт 962 захирамжийг гарсан даруйд нь <a href="http://www.erdenet.mn">www.erdenet.mn</a> сайтад байршуулсан. Лавлагааны санг нийт 989 эрх зүйн актаар шинээр баяжуулж, 71 актын 167 зүйл заалтад нэмэлт өөрчлөлтийг тусган лавлагаа, мэдээллээр үйлчлэх ажлын бэлэн байдлыг хангаж ажиллалаа. Лавлагааны сангаас хууль, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар нийт 51 байгууллага, иргэнд гар болон цахим сангаас лавлагаа мэдээллээр үйлчилсэн байна.	100
<b>2</b>	<b>Зорилт-2: Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</b>						
2.1	Хотын камержуулалтыг сайжруулж, Шуурхай удирдлагын төвтэй	90.0	Ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх	-	Тоног төхөөрөмжөөр хангагдсан байна	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 90.0 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишкатай	100

	<p>холбох ажлыг эрчимжүүлэх</p>					<p>автомашиньг худалдан авч Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. Автовишкатай болсноор давхардсан тоогоор нийт 100 орчим камерын шон дээр 250 гаруй камерыг, дагалдах хэрэгслийн хамт бүрэн шинэчилж засварласан. Гэмт хэрэг ихээр гардаг хар цэгийн судалгааг үндэслэн камер суурилуулах байршил, цэгийг баг бүрээр нарийвчлан гаргаж, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар Уурхайчин багт 17, Цагаанчулуут багт 12, Эрдэнэ багт 36, Булаг багт 35, Хүрэнбулаг багт 26, Зэст багт 7 ширхэг, нийт 133 ширхэг камерыг шинээр нэмж суурилуулан хүлээн авсан.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 649 камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 530 ширхэг, PTZ хөдөлгөөнт 107 ширхэг, хэт ягаан туяаны 2ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 10 ширхэг камер тус тус ажиллаж байна. Камерын хяналтын нэгдсэн төвд 577 иргэн, 40 албан хаагчийн хүсэлтээр 617 удаагийн камерын бичлэг шүүж иргэд, аж ахуйн нэгжид учирсан 352.1 сая төгрөгийн хохирлоос 238.7 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон хохирлыг барагдуулж ажилласан.</p> <p>Дэвшилтэт технологид боловсруулсан өгөгдлийг ашиглан хяналтын камеруудыг үр ашигтай, эдийн засгийн үр өгөөжтэй ашиглаж хиймэл оюун ухаанд суурилсан</p>	
--	-------------------------------------	--	--	--	--	---	--

						системийг нэвтрүүлэх туршилтыг амжилттай хийсэн. Уг систем нь энгийн камераар авто машины дугаар илрүүлэх, хүний биометрик мэдээлэл, царай төрхөөр олж илрүүлэх боломжтой.	
<b>3</b>	<b>Зорилт-3: Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.</b>						
3.1	Түр хамгаалах байрыг байгуулах ажлыг үргэлжлүүлэх		Түр хамгаалах байрыг ашиглалтад оруулах гүйцэтгэлийн хувь	-	100%	2023 онд түр хамгаалах байранд 63 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлж, тус ажилд орон нутгийн төсвөөс 35.6 сая төгрөгийг зарцуулсан. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулан улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлын гүйцэтгэл 90.0 хувьтайгаар барилгын ажил явагдаж байна.	90
<b>4</b>	<b>Зорилт-4: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.</b>						
4.1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх	18,0	Гэмт хэргийн гаралт		Гэмт хэрэг гаргахгүй байх	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, тариур худалдаалах зөвшөөрөлтэй 8 эмийн сан ажиллаж, эм, тариурын хадгалалт, хамгаалалт, орлого, зарлагын тайланд хяналт шалгалтыг явуулж зөвлөгөө, мэдээлэл хүргүүлж ажилласан. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Тархцын хяналт-2023" нэгдсэн арга хэмжээний	100

					<p>хүрээнд 2017 оноос хойш мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, мансуурсан гэх зөрчилд холбогдсон этгээдүүдийн судалгааг гаргаж, эмзэг цэгийг тогтоох чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна. "Туншил" арга хэмжээний хүрээнд эмчийн хуурамч жор үйлдэн сэтгэцэд нөлөөт эм, эмийн сангаас авч хэрэглэсэн 2 иргэнд холбогдох гомдол мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, 1 иргэнээс анхан шатны байдлаар "МЕТ" буюу Метамфетамин агууламж бүхий бодис хэрэглэсэн болох нь тогтоогдсон бөгөөд шинжилгээний дээжийг ШШХ-рүү явуулж, мөрдөн шалгах ажиллагааг тус тус явуулж байна.</p> <p>Улсын хэмжээнд явагдсан "Анзаар" нэгдсэн арга хэмжээ болон аймгийн хэмжээнд "Мансуурал" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж 4101 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгч, цахим орчинд 83 мэдээлэл сэрэмжлүүлгийг байршуулж 47061 иргэнд сэрэмжлүүлэг хүргэж ажилласан.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрт ургасан зэрлэг олсны ургамлын тархацыг аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар хамтран судлан тогтоож, "Устгал-2023" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Баян-Өндөр суманд 15 га, Жаргалант</p>
--	--	--	--	--	--

						<p>суманд 90 га талбайд ургасан олс /каннабис/-ны ургамлыг устгахад орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөгийг зарцууллаа.</p> <p>Жаргалант сумын нутаг дэвсгэрт газар, тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад ногооны талбайн ойр орчимд ургасан сэтгэцэд нөлөөт бодисын агууламжтай каннабисын ургамлын тархцын талаар тайлбарлан ойлгуулж, устгах талаар мэдэгдэл өгч ажилласнаар газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 9 аж ахуйн нэгж 65 га талбайд зэрлэг олсны ургамлыг устгах ажлыг хийсэн байна.</p> <p>Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулснаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт өсөөгүй.</p>	
<b>5</b>	<b>Зорилт-5: Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол түүнээс үүдэх хор уршгийг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.</b>						
5.1	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	10.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	82.3%	90%	<p>Аймгийн хэмжээнд 2021-2024 онд хэрэгжүүлэх 3 зорилт 24 арга хэмжээ бүхий "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллаж байна.</p> <p>Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв, дадал,</p>	100

					<p>мэдлэг олгох, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 17 сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2023" тэмцээнийг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 9.3 сая төгрөг зарцууллаа.</p> <p>"Уусан бол бүү жолоод" нэгдсэн арга хэмжээг 17 удаа зохион байгуулж, өдөр тутмын хяналт шалгалтаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 625 жолоочийг илрүүлэн гарч болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 20 удаа сэрэмжлүүлэг болон мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд олон нийтэд өгсөн. Мөн "Erdenet Traffic Paparazzi" цахим хаягт байршуулсан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 28 жолоочид арга хэмжээ тооцон ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 30883 жолоочийг 741.8 сая төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1335, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 212 жолоочийг илрүүлэн нийт 42.4 сая төгрөгөөр торгож ажилласнаар согтуугаар тээврийн</p>
--	--	--	--	--	--



						хэрэгсэл жолоодсон зөрчил 29.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тээврийн хэрэгслийн хурд хэмжигч ТРСАМ багажийг худалдан авч, албан хэрэгцээнд ашиглаж байна. 2023 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласнаар хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.	
<b>6</b>	<b>Зорилт-6: Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ үйлчилгээг сайжруулна.</b>						
6.1	Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	6,0	Албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	19	25	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр гудамж талбай, олон нийтийн газруудад хөдөлгөөнт болон явган эргүүлийн 8-10 чиглэлд 16-20 алба хаагчийг тогтмол ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шаг", "Ахуй хүрээний архидалт", "Хяналт" зэрэг 34 тусгай арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан. Хууль тогтоомж зөрчин гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хориглосон газар, хугацаанд үйл ажиллагаа явуулж архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 34 зөрчил илрүүлэн 21 иргэн, 13 хуулийн этгээдийг 71.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч, 20 литр архи, 70 литр пиво, 112.8	100

						<p>мянган төгрөгийн хууль бус орлогыг хураан авсан.</p> <p>Орон гэргүй, тэнэмэл, архи согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэж, гудамж талбайд зөрчил үйлддэг иргэдийн судалгааг гарган Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэтгэц, наркологийн төвтэй хамтран 10 иргэнийг албадан, "Ариунсаруулбат" НҮТББ-тай хамтран 20 иргэнийг сайн дурын нийт 30 иргэнийг архины эмчилгээнд хамруулсан.</p> <p>Орон нутагт согтуугаар үйлдсэн 188 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оноос 4.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	
<b>7</b>	<b>Зорилт-7: Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</b>						
7.1	Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх	667,7	Үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх	-	Шаардлагатай дэмжлэг үзүүлсэн байна.	<p>2023 онд аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж худалдан авахад 50.0 сая, Улсын бүртгэлийн хэлтэст киоск машин худалдаж авахад 28.0 сая, Архивын тасагт байнга хадгалах баримтыг сэргээн засварлахад 5.0 сая төгрөг, Мэдээлэл шуурхай удирдлагын төв автовишка худалдан авахад 90.0 сая төгрөг, ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт оёдлын машин худалдан авахад 65.2 сая төгрөг, Цагдаагийн газарт олон нийтийн цагдаагийн цалин, тоног төхөөрөмж худалдан авахад 504.0 сая нийт 829.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдлээ. Үүнд:</p>	100

					<p>ШШГГ-т эмнэлгийн багаж хэрэгсэл худалдан авч өвчтөн хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 18.0 сая төгрөг шийдвэрлүүлж зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтнуудад техникийн хяналт тогтоох, сургалтад шаардагдах 2 ширхэг ухаалаг дэлгэцийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Малын тамганы цахим сан бүрдүүлэхэд орон нутгийн төсвөөс 4.9 сая төгрөгийг шийдвэрлэснээр "Малын тамганы цахим бүртгэл" SUREG.MN системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, аймгийн адууны тамганы санг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтэст иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, гэрээт ажилтан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 25.2 сая төгрөгийг батлуулж, ажилтны цалин, НДШ-ийг төлж байна.</p> <p>Цагдаагийн газарт Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 40 орон тоогоор батлуулж, цалингийн хэмжээг нэмэгдүүлэн, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 459.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, өдөр тутмын удирдлага</p>
--	--	--	--	--	---

						зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Замын цагдаагийн тасагт замын хяналт хэрэгжүүлэхэд шаардагдах пүүг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд 35.6 сая төгрөгийг зарцууллаа.	
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>							
1.1	Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог, бэхжүүлж, томилгоот нэгжийн бэлтгэлийг хангах, нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх	УТ, ОНТ	Томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх чадвар дээшилсэн байх	Сургалтыг зохион байгуулсан	Томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулна	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны А/843 дугаар захирамжаар Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-наас 17-ны өдрүүдэд аймгийн Засаг даргаар батлагдсан хөтөлбөр, хичээлийн хуваарийн дагуу Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын танхим болон Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион явуулсан.	100
1.2	Эх оронч үзэл хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлж иргэн	УТ, ОНТ	Хүүхэд, залуучуудын цэрэг-эх оронч үзэл олгож	Төлөвлөсөн 3-аас доошгүй	Төлөвлөсөн 3-аас доошгүй ажил зохион байгуулах	“Бидний бахархал” төслийн хүрээнд “Олон улсын энхийг сахиулагчдын өдөр буюу 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр аймгийн төв талбай	100

	<p>цэргийн харилцааг бэхжүүлж иргэдэд цэргийн боловсрол олгох</p>		<p>мэдлэгийн түвшин дээшилсэн байх</p>	<p>ажил зохион байгуулсан</p>		<p>болох Монгол Улсын Ерөнхий сайд асан Агданбуугийн Амарын талбайд “Монгол цэрэг-Энхийн төлөө” нээлттэй хаалганы өдөрлөгийг Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангийг оролцуулан өргөн хүрээнд зохион явуулсан.</p> <p>“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиуд, Орхон аймаг дахь Монгол цэргийн нэгдсэн холбоотой хамтран Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор сургууль”, Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл болгон нийт 200 гаруй оюутан, сурагчдад “Бидний бахархал” сэдэвт лекц зохион байгуулсан.</p> <p>Монгол цэргийн нэгдсэн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор, профессор дэслэгч генерал Ц.Тогоогоор ахлуулсан “Бидний бахархал” төслийн албан ёсны нээлтийн арга хэмжээг Монгол цэргийн нэгдсэн холбоотой хамтран “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Соёл урлагийн цогцолборт зохион байгуулсан. Тус нээлтийн арга хэмжээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага болон алба хаагчид, их дээд сургуулиудын оюутнууд, Ерөнхий боловсролын сургуулиудын</p>
--	---	--	--	-------------------------------	--	--

						ахлах ангийн сурагчид 500 хүнийг хамруулсан.	
1.3	Дайчилгааны төлөвлөгөөг эдийн засгийн нөхцөлд тулгуурлан шинэчлэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүний тоо, чанар материаллаг баазыг сайжруулах	УТ, ОНТ	Бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо, материаллаг бааз	Боловсруулалт Хийгдсэн	Бэлэн байдал хангагдана	“Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-ний дагуу Баян-Өндөр, Жаргалант сумдын дайчилгааны төлөвлөгөөнд 2, 4 дүгээр улирлуудад тодотгол хийж, нөхөн томилгоожуулсан. “Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-ний дагуу Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай хамтарсан тодотгол хийж акт <b>НОТЛОМЖИЙГ</b> Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.	100

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

<b>1</b>	<b>Зорилт-1: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх</b>						
1.1	Тамгын газрын санхүүгийн чадавхыг дээшлүүлэх	-	Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, заавар журамд нийцсэн байх.	Батлагдсан хуваарийн дагуу зарцуулагдаж, өр авлагагүй ажилласан.	Санхүүгийн чадавх сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэнэ.	2023 онд орон нутгийн төсвөөс 3.964.360.800 төгрөг, нэмэлт дансаар ЗГНХ, түүнтэй адитгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн орлого 248.107.969 төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс, доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлогоос 42.135.796 төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээд бий болсон орлого 134.692.702 төгрөг, Засгийн газрын 419 дүгээр тогтоолын дагуу 200.000.000 төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 10.024.978 төгрөгийн санхүүжилтийг	100

						<p>тус тус зарцуулалтыг олгосон.Төвлөрүүлэх шилжүүлэг үндсэн данснаас 496.107.232.96 төгрөг, нэмэлт данснаас 24.483.700 төгрөг нийтдээ 520.590.932.56 төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.</p> <p>Төвлөрүүлэх шилжүүлэг 520.590.932.56 төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн байна.</p>	
1.2	Тамгын газрын аж ахуйн үйлчилгээ, материаллаг нөөцийг сайжруулах	Орон нутгийн төсөв	Худалдан авах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд байх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн байх	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдсан	Ажиллах орчин нөхцөл сайжирна. Тамгын газрын аж ахуйн үйлчилгээний чанарт ахиц гарна.	<p>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5.116.543.692.03 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнээс:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. /Барилга байгууламж-3.056.123.977 төгрөг/,</li> <li>2. Тоног төхөөрөмж-1.487.738.508.03 төгрөг/,</li> <li>3. Тавилга эд хогшил-323.169.543 төгрөг</li> <li>4. Тээврийн хэрэгсэл-192.454.000 төгрөг,</li> <li>5. Программ хангамж-54.580.000 төгрөг</li> <li>6. Бусад үндсэн хөрөнгө-2.477.664 төгрөг.</li> </ol> <p>Жаргалант сумаас 33.000,000 төгрөгийн, Төрийн тусгай хамгаалалтын газраас 32.255.460 төгрөгийн, Мэргэжлийн хяналтын газраас 115.368.720 төгрөгийн автомашиныг тус тус шилжүүлэн авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн. Дэгжин өргөө ХХК-аас Цэргийн штаб албан хэрэгцээнд суудлын автомашин 31.000.000 төгрөгийн суудлын</p>	100

					<p>автомашин өөрийн орлогоос худалдан авсан. Төрийн тусгай хамгаалалтын газраас ирсэн 1 тээврийн хэрэгслийг өмч хамгааллын байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн мэргэжлийн үнэлгээний компаниар үнэлгээ хийлгэн үнэ тогтоолгосон 2.454.000 төгрөгөөр орлогод хүлээн авсан. Орон нутгийн өмчийн газрын дуудлага худалдаагаар 185.500.000 төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг зарж борлуулсан ба үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассан. Жаргалант сумын ЗДТГ, Хотын захирагчийн албанд 158.500.000 төгрөгийн өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг Засаг даргын А/259 тоот захирамжийн дагуу балансаас балансанд шилжүүлсэн байна. Төрийн тусгай хамгаалалтын газраас шилжүүлэн авсан тээврийн хэрэгслийг үнэлгээ тогтоолгон бүртгэж авлаа.</p> <p>Өөрийн хөрөнгөөр:</p> <ul style="list-style-type: none"><li>- Машин тоног төхөөрөмж 91.279.300 төгрөг,</li><li>- Тээврийн хэрэгсэл 31.000.000 төгрөг,</li><li>- Тавилга эд хогшил 8905.500 төгрөг үндсэн хөрөнгийг тус тус бүртгэж авсан байна.</li></ul> <p>2023 оны 9 дүгээр сарын 18 өдрийн А/699 тоот тушаалаар 106.4022.716.70 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталсан. Хөрөнгө актлах, шилжүүлэх, бүртгэлээс хасах, худалдах тухай</p>
--	--	--	--	--	---



						2023 оны 12 дугаар сарын 22 өдрийн А/1008 тоот захирамжийн дагуу Статистикийн хэлтэст 3.171.300 төгрөгийн хөрөнгийн шилжүүлэн бүртгэсэн байна.	
<b>Үнэлгээний дундаж 97.3%</b>							

*Хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

Аймгийн Засаг даргын орлогч ..... /М.Түмэнжаргал/

*Тэмдэг*

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**

Аймгийн ЗДТГ-ын дарга ..... /Ш.Ганболд/

*Тэмдэг*

*Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

ЗДТГ-ын ХШҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... /Ж.Баасансүрэн/